



2021 оны 04 дүгээр сарын 16
№15 /1165/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

ᠲᠦ᠋ᠷᠢᠶᠢᠨ
ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠤᠯ ᠠᠯᠪᠠᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠤᠯ
ᠠᠯᠪᠠᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ





| | | |
|-------|---|-------|
| 9᠒᠓᠓᠐ | <p>Үсрлэгчид, үсрлэгчдийн хамт олон ажиллагаа, үсрлэгчдийн хамт олон ажиллагаа, үсрлэгчдийн хамт олон ажиллагаа</p> | • ᠑᠒᠖ |
| 9᠒᠓᠓᠐ | <p>Үсрлэгчид, үсрлэгчдийн хамт олон ажиллагаа, үсрлэгчдийн хамт олон ажиллагаа, үсрлэгчдийн хамт олон ажиллагаа</p> | • ᠘᠒᠖ |
| 9᠒᠓᠓᠑ | <p>Үсрлэгчид, үсрлэгчдийн хамт олон ажиллагаа, үсрлэгчдийн хамт олон ажиллагаа, үсрлэгчдийн хамт олон ажиллагаа</p> | • 7᠒᠖ |
| 9᠒᠓᠓᠒ | <p>Үсрлэгчид, үсрлэгчдийн хамт олон ажиллагаа, үсрлэгчдийн хамт олон ажиллагаа, үсрлэгчдийн хамт олон ажиллагаа</p> | • ᠗᠒᠖ |



ГАРЧИГ
МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- | | | |
|------|---|------|
| 141. | Нэмэлт санхүүжилтийн хэлэлцээр соёрхон батлах тухай | 1224 |
| 142. | Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | 1225 |

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- | | | |
|------|---|-------------------|
| 143. | Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох, Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлөх тухай | Дугаар 31 1227 |
| 144. | Байнгын хорооны даргыг сонгох, чөлөөлөх тухай | Дугаар 32 1228 |
| 145. | Ерөнхийлөгчийн хоригийн тухай | Дугаар 35 1229 |

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- | | | |
|------|--|---------------------|
| 146. | Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай | Дугаар 144а 1230 |
| 147. | Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай | Дугаар 21 1230 |

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- | | | |
|------|--------------------|--------------------|
| 148. | Журам батлах тухай | Дугаар 229 1231 |
|------|--------------------|--------------------|

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

- | | | |
|------|--|------|
| 149. | “Монгол Улсад Ковид-19-өөс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төсөл” | 1267 |
|------|--|------|



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 04 дүгээр
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улс болон Олон улсын хөгжлийн ассоциаци хооронд 2021 оны 02 дугаар сарын 15-ны өдөр байгуулсан “Монгол Улсад Ковид-19-өөс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төсөл”-ийн нэмэлт Санхүүжилтийн хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Үснийг мийрмэр мийрмэр

Мийрмэрмийрмэр мийрмэр

Мийрмэр мийрмэр мийрмэр 00 0 мийрмэр 0000

Мийрмэр мийрмэр мийрмэр

Мийрмэр мийрмэр

Мийрмэр мийрмэр мийрмэр мийрмэр мийрмэр мийрмэр

Мийрмэр мийрмэр мийрмэр мийрмэр мийрмэр мийрмэр

Мийрмэр мийрмэр мийрмэр мийрмэр мийрмэр мийрмэр

Мийрмэр мийрмэр мийрмэр мийрмэр мийрмэр мийрмэр

Мийрмэр мийрмэр мийрмэр мийрмэр мийрмэр мийрмэр

Мийрмэр мийрмэр мийрмэр мийрмэр мийрмэр мийрмэр

Мийрмэр мийрмэр мийрмэр мийрмэр мийрмэр мийрмэр

Мийрмэр мийрмэр мийрмэр мийрмэр мийрмэр мийрмэр

Мийрмэр мийрмэр мийрмэр мийрмэр мийрмэр мийрмэр

Мийрмэр мийрмэр мийрмэр мийрмэр мийрмэр мийрмэр

Мийрмэр мийрмэр мийрмэр мийрмэр мийрмэр мийрмэр

Мийрмэр мийрмэр мийрмэр мийрмэр мийрмэр мийрмэр

Мийрмэр мийрмэр мийрмэр мийрмэр мийрмэр мийрмэр

Мийрмэр мийрмэр мийрмэр мийрмэр мийрмэр мийрмэр

Мийрмэр мийрмэр мийрмэр мийрмэр мийрмэр мийрмэр

Мийрмэр мийрмэр мийрмэр мийрмэр мийрмэр мийрмэр

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 04 дүгээр
сарын 02-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 13 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 13.6, 13.7 дахь хэсэг нэмсүгэй:

“13.6. Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 10.2-т заасны дагуу Хүний эрх хамгаалагчийн асуудал эрхэлсэн гишүүнийг Комиссын гишүүд дотроосоо нэг жилийн хугацаагаар олонхын саналаар нууц санал хураалтаар зөвхөн нэг удаа сонгоно.

13.7. Энэ хуулийн 13.6-д заасан гишүүн Хүний эрхийн Үндэсний Комиссын даргаар томилогдсон, эсхүл өөр ажил албан тушаалд сонгогдсон, томилогдсон бол Комиссын гишүүд 14 хоногийн дотор Хүний эрх хамгаалагчийн асуудал эрхэлсэн гишүүнийг сонгоно.”

2 дугаар зүйл. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “таван” гэснийг “зургаан” гэж, 12 дугаар зүйлийн 12.5 дахь хэсгийн “15 хоногийн” гэснийг “60 хоногийн” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2021 оны 4 дүгээр сарын 08-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2020 оны 12 дугаар
сарын 15-ны өдөр

Дугаар 144 а

Улаанбаатар
хот

Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Өөр албан тушаалд томилогдсон тул Цэндийн Цогтыг Нийслэлийн Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2021 оны 02 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар 21

Улаанбаатар
хот

Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөгдөх хүсэлтээ бичгээр гаргасан шүүгч Төртогтохын Наранцогтыг Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 12 дугаар
сарын 23-ны өдөр

Дугаар 229

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Цөмийн энергийн тухай хуулийн 33.4 дэх хэсэг, “Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх гэрээтэй холбогдуулан баталгаа хэрэглэх тухай” Монгол Улсын Засгийн газар, Олон улсын атомын энергийн агентлаг хооронд байгуулсан хэлэлцээр (INFCIRC/188)-ийг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Цөмийн материалыг бүртгэх, хянах журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Т.Гантулга), Цөмийн энергийн комиссын Ажлын алба (Г.Манлайжав)-д тус тус үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

У.ХҮРЭЛСҮХ

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Засгийн газрын 2020 оны 229 дүгээр тогтоолын хавсралт

АГУУЛГА

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Зорилго
- 1.2. Хамрах хүрээ

Хоёр. Цөмийн материалын бүртгэл, тооллогын үйл ажиллагаа

- 2.1. Цөмийн материалын бүртгэл, тооллого
- 2.2. Цөмийн энергийн комиссын Ажлын албанаас авч хэрэгжүүлэх арга хэмжээ

2.3. Мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас авч хэрэгжүүлэх арга хэмжээ

2.4. Цөмийн материалтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагын цөмийн материалын дотоод бүртгэл

2.5. Цөмийн материалтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагаас авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Гурав. Урьдчилсан мэдэгдэл хүргүүлэх тухай

3.1. Цөмийн материалыг экспортлохтой холбоотой урьдчилсан мэдэгдэл хүргүүлэх тухай

3.2. Цөмийн материалыг импортлохтой холбоотой урьдчилсан мэдэгдэл хүргүүлэх тухай

Дөрөв. Мэдээлэл хүргүүлэхтэй холбоотой үүрэг, хариуцлага

4.1. Шинээр цөмийн байгууламж барих шийдвэрийг хэрэгжүүлэгч мөн цөмийн материалтай холбоотой үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг, хариуцлага

4.2. Ураны хайгуул, олборлолтын үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж байгууллагын үүрэг, хариуцлага

4.3. Цөмийн түлшний циклд эрдэм шинжилгээ болон туршилт-зохион бүтээх ажиллагаа явуулах аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг, хариуцлага

Тав. Хяналт

5.1. Цөмийн энергийн комиссын Ажлын албанаас хэрэгжүүлэх үйл ажиллагаа

5.2. Мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас хэрэгжүүлэх үйл ажиллагаа

5.3. Баталгааны тухай хэлэлцээрийн дагуу баталгаанд хамрагдахаас чөлөөлөгдөх

5.4. Олон улсын атомын энергийн агентлагийн хяналт, шалгалт болон ОУАЭА-ийн шинжээчдийн хэрэгжүүлэх үйл ажиллагаа

5.5. Хяналт шалгалтад хамрагдаж буй байгууллагаас хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Хавсралт 1. Цөмийн материалыг бүртгэх, хянах журам (ЦМБХЖ)-ын тайлангууд:

Маягт 1. Биет үзлэг тооллогын тайлан

Маягт 2. Материалын тэнцлийн тайлан

Маягт 3. Тооллогын өөрчлөлтийн тайлан

Маягт 4. Монгол Улсаас экспортод гаргахаар төлөвлөж буй цөмийн материалыг урьдчилан мэдэгдэх маягт

Маягт 5. Монгол Улсад цөмийн материал импортлохоор төлөвлөж буй цөмийн материалыг урьдчилан мэдэгдэх маягт

Хавсралт 2. Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх гэрээтэй холбогдуулан баталгаа хэрэглэх тухай Монгол Улс, ОУАЭА-ийн хооронд байгуулсан хэлэлцээрийн нэмэлт протоколын мэдүүлгүүд

Маягт 1. Цөмийн материалтай холбоогүй боловч цөмийн түлшний циклд эрдэм шинжилгээ, судалгаа хийх, зохион бүтээх ажиллагааны тухай мэдээлэл

Маягт 2. Байршлын ерөнхий тодорхойлолт болон мэдээлэл- (байршил бүрд байгаа барилгын ерөнхий тодорхойлолт, ашиглалтын чиглэл, байршлын газарзүйн зураг)

Маягт 3. Нэмэлт протоколын 1 дүгээр хавсралтад дурдсан үйл ажиллагаанд хамаарах байршил бүрд хамаарах үйл ажиллагааны цар хүрээний тодорхойлолт

Маягт 4. Ураны хайгуул, олборлолт, боловсруулах үйлдвэр, торийн боловсруулах үйлдвэрийн жилийн урьдчилан тооцсон бүтээгдэхүүн үйлдвэрлэл, ашиглалтын байдал, байршлын мэдээлэл, тэдгээр уурхай болон боловсруулах үйлдвэрийн жилийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл (одоогийн)

Маягт 5. Түлшний үйлдвэрлэл, эсвэл изотопоор баяжуулахад цэвэршилт болон найрлагын хувьд шаардлага хангахгүй эх үүсвэр материалын мэдээлэл

Маягт 6. Баталгаанд хамрагдахаас чөлөөлөгдөх цөмийн материалын ашиглалтын төрөл болон байршил



Маягт 7. Баталгаанд хамрагдах хугацаа нь дуусгавар болсон плутони, өндөр баяжуулсан уран, эсвэл уран-233 агуулсан дунд, эсвэл өндөр зэрэглэлийн идэвх бүхий хаягдлын байршил болон цаашдын боловсруулалтад хамаарах мэдээлэл

Маягт 8. Нэмэлт протоколын 2 дугаар хавсралтад дурдсан цөмийн бус материалд хамаарах мэдээлэл болон багаж төхөөрөмжийн экспорт, эсвэл импорттой холбоотой мэдээлэл

Маягт 9. Цөмийн түлшний циклд хамаарах эрдэм шинжилгээ, судалгаа хийх, зохион бүтээх ажиллагаатай холбоотой дараагийн 10 жилийн ерөнхий төлөвлөгөө

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Зорилго

Энэ журмын зорилго нь цөмийн материал (эх үүсвэр материал, хуваагдах тусгай материал), цацраг идэвхт хүдрийн баяжмалыг бүртгэх, хянах, мэдүүлэг хүргүүлэх харилцааг зохицуулах болон “Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх тухай гэрээтэй холбогдуулан баталгаа хэрэглэх тухай Монгол Улс, Олон улсын атомын энергийн агентлаг (цаашид “ОУАЭА” гэх)-ийн хооронд байгуулсан Хэлэлцээрт оруулсан нэмэлт протокол (IN-FCIRC/188/add.1)”-ын дагуу Монгол Улсын хүлээсэн үүргийг биелүүлэхэд оршино.

1.2. Хамрах хүрээ:

1.2.1. Цөмийн материалыг бүртгэх, хянах журмыг дараах үйл ажиллагаанд дагаж мөрдөнө:

а) Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, этгээдийн энхийн зорилгоор ашиглах цөмийн материал¹ болон түүнтэй

¹ а) Цөмийн материал гэдэг нь ОУАЭА-ийн дүрмийн XX зүйлд тодорхойлсны дагуу эх үүсвэр материал болон аливаа хуваагдах цөмийн тусгай материалыг хэлнэ. Эх үүсвэр материал нь байгалийн уран, эсвэл байгальд орших изотопуудын холимогийг агуулсан уран, уран-235 изотопоор ядуурсан уран, тори тэдгээрийн аливаа төрлийн металл, хайлш, химийн нэгдэл, баяжмал хэлбэрээр байх дээр дурдсан материалын аль ч байж болно. Эх үүсвэр материалд хүдэр, хүдрийн хаягдал хамаарахгүй.

б) Хуваагдах цөмийн тусгай материал нь байгаль дээр оршдоггүй бөгөөд эх үүсвэр материалаас гаргаж авна. Уран-233, плутони-239, уран-235 болон уран-233 изотопоор баяжуулсан уран нь хуваагдах цөмийн тусгай материалд орно.

в) Баяжуулалт гэдэг нь уран-235 изотопыг нийт уранд харьцуулсан жингийн харьцаа:

- баяжуулсан уран гэдэг нь уран-235 изотоп 0.72%-аас дээш агууламжтай уран;
- ядууруулсан уран гэдэг нь уран-235 изотоп 0.71%-аас доош агууламжтай уран;

холбоотой үйл ажиллагаа²;

б) цөмийн түлшний үе шатанд эрдэм шинжилгээ болон туршилт-зохион бүтээх ажиллагаатай³ урт хугацааны төлөвлөгөө, үйлдвэрлэл, хадгалалт, экспорт, импортын үйл ажиллагаа;

в) ураны хайгуул, олборлох, ураны хүдрийн баяжмал үйлдвэрлэх, ураны хүдрийн баяжмал экспортлох, импортлох үйл ажиллагаа.

1.2.2.Цөмийн материалын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд энэхүү журам хамаарахгүй.

-байгалийн уран гэдэг нь байгаль дээр оршдог уран-235 изотоп 0.71-0.72% агууламжтай уран;

-өндөр баяжуулсан уран гэдэг нь 20% ба түүнээс дээш хэмжээгээр баяжуулсан уран.

г) Ураны уурхай, хүдэр баяжуулах үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллага нь ураны хүдрийг баяжуулахад шаардлагатай найрлага ба цэвэр байдлын түвшинг “Standard Specification for Nuclear-Grade, Sinter able Uranium Dioxide Powder” (ASTM C 753-04) стандартын дагуу итгэмжлэгдсэн лабораториор тодорхойлуулна.

д) Ураны хүдрийг баяжуулахад шаардлагатай найрлага ба цэвэр байдлын түвшин ASTM C753-04 стандартад нийцвэл түлшний зэргийн ураны хүдрийн баяжмал гэнэ.

е) Ураны хүдрийг баяжуулахад шаардлагатай найрлага ба цэвэр байдлын түвшин ASTM C753-04 стандартад үл нийцвэл түлшний бус зэргийн ураны хүдрийн баяжмал гэнэ.

²Цөмийн материал болон түүнтэй холбоотой үйл ажиллагаа гэдэг нь цөмийн материалыг эзэмших, гарган авах, үйлдвэрлэх, хадгалах, ашиглах, өөрчлөх, дотооддоо худалдах, экспортлох, импортлох, хадгалалт, эсвэл хаягдал болгох үйл ажиллагааг хэлнэ.

³Цөмийн урвалаар цахилгаан эрчим хүч үйлдвэрлэхтэй холбоотой олон төрлийн үйл ажиллагааг хөгжүүлэх болон тэдгээрийн судалгаа боловсруулалттай холбоотой аливаа үйл явцыг хэлнэ:

а) цөмийн материалыг хувиргах;

б) цөмийн материалыг баяжуулах;

в) цөмийн түлш үйлдвэрлэх;

г) цөмийн реакторыг хөгжүүлэх;

д) критик байгууламжийг хөгжүүлэх;

е) цөмийн түлшийг дахин боловсруулах;

ё) плутони, өндөр баяжуулсан уран, эсвэл уран-233 агуулсан дунд, эсвэл өндөр түвшний хаягдлыг боловсруулах (дахин савлах, эсвэл элементүүдийг ялгахыг оруулахгүйгээр боловсруулах, хадгалах, эсвэл хаягдал болгох), гэхдээ онолын, эсвэл шинжлэх ухааны суурь судалгаа болон үйлдвэр, анагаах ухаан, гидрологи, хөдөө аж ахуйд ашиглах цацраг идэвхт изотопуудтай холбоотой үйл ажиллагаа, эрүүл мэнд, гадаад орчны нөлөөг энд оролцуулахгүй.

Хоёр. Цөмийн материалын бүртгэл, тооллогын үйл ажиллагаа

2.1. Цөмийн материалын бүртгэл, тооллого:

2.1.1. Цөмийн материалтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага нь цөмийн материал гол төлөв ашиглагддаг байршилд хамаарах цөмийн материалыг бүртгэлд хамруулна. Цөмийн материалыг бүртгэх, хянах үйл ажиллагаанд үйлдвэрлэлийн шатнаас булшлах хүртэлх хугацааг хамруулна;

2.1.2. Цөмийн материалын бүртгэл, хяналт нь Монгол Улсад энхийн зорилгоор цөмийн материалыг ашиглаж буйг баталгаажуулах, түүний тоо, хэмжээ, байршил, хамаарах үйл ажиллагаа, шилжилт хөдөлгөөнийг⁴ бүртгэн, тэдгээрийг хууль бусаар ашиглахаас урьдчилан сэргийлэх зорилготой;

2.1.3. Цөмийн материалын бүртгэл, хяналтын тогтолцоо нь энэ журмын 1.2.1-д заасан иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаан дээр үндэслэнэ.

2.1.4. Цөмийн материалтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагын цөмийн материалын бүртгэлд дараахь мэдээллийг агуулсан байх ба олон улсын тайлангийн шаардлагын дагуу мэдээллийн өгөгдлийг үнэн зөв оруулсан байна:

а) цөмийн материалын элемент бүрийн (уран, плутони, тори) ангилал ба тоо хэмжээ болон байгууллага бүрийн эзэмшиж байгаа цөмийн материал дахь хуваагдах цөмийн агуулга болон нийлбэр агуулга;

б) цөмийн материал эзэмшигч байгууллагууд хоорондох цөмийн материалын шилжилт хөдөлгөөн.

2.2. Цөмийн энергийн комисс (цаашид “ЦЭК” гэх)-ын Ажлын албанаас⁵ дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

2.2.1. Улсын хэмжээний цөмийн материалын бүртгэл, хяналтын тогтолцоог бий болгох, баталгааны гэрээ болон нэмэлт протоколоор хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангана;

⁴Цөмийн материалын шилжилт хөдөлгөөн гэдэг нь материалын тэнцлийн хэсэгт орсон, гарсан шилжилт хөдөлгөөн буюу цөмийн материалын бүртгэлд орж буй өөрчлөлтийг хэлнэ.

⁵ЦЭК-ын Ажлын алба нь цөмийн материалыг бүртгэх, хянах үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий байгууллага.

2.2.2. Нэмэлт протоколын 2.а. (iii)⁶ мэдүүлэгт заасан эрх үүргээ биелүүлэхийн тулд түлшний уран болон бусад цөмийн материал агуулсан байршил, цөмийн материалын багцын төрлийг ОУАЭА-ийн дэмжлэгтэйгээр тогтооно. Цөмийн материалыг багцаар тоолох бөгөөд багцын төрлийг ЦЭК-ын Ажлын албанаас тогтооно. Багцын төрлийг тогтоосон шийдвэрийг аж ахуйн нэгж, байгууллагад хүргүүлнэ;

2.2.3. Цөмийн материалыг багцаар⁷ тоолох бөгөөд багцын мэдээлэлд цөмийн материал дахь элемент тус бүрийн нийлбэр жин болон шаардлагатай тохиолдолд уран, плутонийн хувьд изотоп тус бүрийн мэдээллийг багцын мэдээлэлд тусгана;

2.2.4. Монгол Улс нь баталгааны тухай хэлэлцээр⁸ болон нэмэлт протоколоор хүлээсэн үүргийг хэрэгжүүлэгч ЦЭК-ын Ажлын алба болон мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь мэдээлэл хүргүүлэх үүрэг бүхий цөмийн материал эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагуудаас энэхүү журамд заасан тайланг ирүүлэхийг шаардахаас гадна нэмэлт тодотгол, тайлбар гаргуулан авах эрхтэй;

2.2.5. Цөмийн материалыг бүртгэх, хянах журмын дагуу авсан мэдээллийг зөвхөн чиг үүрэгтэй холбоотой зорилт болон баталгааг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд ашиглана.

2.3. Мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага⁹-аас дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

2.3.1. Цөмийн материалтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагад төлөвлөгөөт ба төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийх бөгөөд төлөвлөгөөт хяналт шалгалт хийх хугацааг Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасан хугацаанд урьдчилан мэдэгдэнэ;

⁶Нэмэлт протоколын 2.а. (iii) мэдүүлэгт цөмийн материал байрлаж буй байршил болон барилга байгууламжийн байршлын тухай мэдээллийг тусгана.

⁷Цөмийн материалын багц нь бүртгэл тооллогын үндсэн элемент юм. Багцыг тусгай ID дугаараар тодорхойлох ба тухайн багц тус бүрд цөмийн материалын хэмжээг нэг бүрчлэн зааж өгнө. Багцад нэг, түүнээс дээш зүйл байж болно. Бараа материалын бүртгэлийн үндсэн цэгүүд нь материалын тэнцлийн хэсэгт байгаа бүх цөмийн материалыг хэмжихээс эхэлнэ.

⁸Иж бүрэн Цөмийн аюулгүй байдлын баталгааны тухай хэлэлцээрт (Comprehensive Safeguards Agreement-1972) Монгол Улс 1972 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр нэгдэн орсон. Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх гэрээний баталгааг хэрэглэх тухай Нэмэлт протоколд Монгол Улс нэгдэн орж 2001 оны 12 дугаар сард гарын үсэг зурсан бөгөөд УИХ-аас 2003 онд соёрхон баталж, ОУАЭА-т 2003 оны 05 дугаар сарын 12-ны өдрөөс протоколыг хүчин төгөлдөр мөрдөж байна.

⁹Мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь Цөмийн материалын улсын бүртгэл хөтлөх, баталгааны хяналт тавих эрх бүхий байгууллага.



2.3.2. Цөмийн материалтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагаас тайлагнавал зохих мэдээллээс гадна нэмэлт мэдээлэл, тайлбар ирүүлэхийг шаардаж болно;

2.3.3. Тоо бүртгэлийн тогтолцоог бүрдүүлэхэд ашигласан баримт бичгүүд болон хяналт шалгалтын үед хийгдсэн цөмийн материалын бүртгэлүүд нь тоо бүртгэлийн тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг болно;

2.3.4. Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь тайланд алдаа болон зөрүүг илрүүлбэл шалтгааныг тогтоох, тайлбар гаргуулан авах үүрэгтэй.

2.4. Цөмийн материалтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагын дотоод бүртгэл:

2.4.1. Цөмийн материалтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага нь өөрийн өмчлөлд байгаа, эсвэл өөрсдийн үйл ажиллагаанд ашигладаг цөмийн материалын тоо хэмжээ, түүнийг хэмжсэн хэмжилтийн дүн, цөмийн материалын шилжилт хөдөлгөөн, байршил, бүртгэл, тооллогоос хасагдсан мэдээллүүд дээр үндэслэн цөмийн материалын бүртгэлийн тогтолцоог бүрдүүлнэ. Энэхүү бүртгэлийн тогтолцоо нь Баталгааны тухай хэлэлцээрт заасан шаардлагуудыг хангасан байна;

2.4.2. Дотоод бүртгэлийн тогтолцоондоо өөрийн өмчлөлд байгаа цөмийн материалын тоо хэмжээ¹⁰ төрөл болон тэдгээрт агуулагдаж буй хуваагдах цөм тус бүрээр ямар ч үед тодорхойлж болохуйц нөхцөлийг хангасан байна;

2.4.3. Дотоод бүртгэлд оруулах тоон мэдээллийг тухайн материалын дагалдан ирэх баримт бичгүүдийг үндэслэсэн эсвэл хэмжилтийн дүн болон биет тооллогод тулгуурласан анхны тооллогын тайланд үндэслэн хийгдэнэ. Багц дотор орох нэгж материалын жинг тайланд тусгахдаа ижил нэгжид шилжүүлнэ;

2.4.4. Хэмжилтийн эсвэл тооцооллоор гарган авсан аливаа багцад агуулагдах цөмийн материалын хэмжээг бүртгэлжүүлж, анхны тайланг гаргаснаар дотоод бүртгэлийн тогтолцоо бүрдсэн гэж үзнэ;

2.4.5. Энэ журмын 2.2.4-т заасны дагуу гаргаж өгсөн тайлангийн талаарх тодотгол буюу тайлбарыг баталгааны зорилгод хамаарах тэр цар хэмжээгээр гаргаж өгнө;

¹⁰Цөмийн материалын тоо хэмжээ гэдэг нь байгууламж эсвэл байгууламжаас бусад байршилд байгаа цөмийн материалын тоог хэлнэ.

2.4.6. Цөмийн материалтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага нь баталгааны тухай хэлэлцээрийн 35, 36 дугаар зүйлүүдийг үндэслэн баталгааны хяналтаас чөлөөлөгдөх цөмийн материалыг чөлөөлөгдөх шалтгаан хүчингүй болохоос 21 хоногийн өмнө дотоод бүртгэлийн системд тусгана;

2.4.7. Дотоод бүртгэл болон ашиглалтын бүртгэлийг зөвшөөрөлгүй этгээд ашиглахаас урьдчилан сэргийлэх зорилгоор мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангана.

2.5. Цөмийн материалтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага нь дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

2.5.1. Цөмийн материалын бүртгэл, тооллогын үйл ажиллагаа буюу баталгааны асуудал хариуцах нэгж, эсвэл мэргэжлийн ажилтантай байна. Тус асуудлыг хариуцсан эрх бүхий албан тушаалтан эсвэл нэгжийг тушаалаар томилж, түүний хүлээх үүрэг хариуцлага, баталгааны талаарх байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, байршил, холбоо барих мэдээлэл зэргийг байгууллагын дотоод журамдаа тусгана;

2.5.2. Цөмийн материалын бүртгэлтэй холбоотой аливаа өөрчлөлтийг ажлын 3-аас доошгүй хоногийн дотор багтаан, дотоод тоо бүртгэлийн системд оруулах ба огноо, өөрчлөлтийн шалтгаан, хүлээн авагч болон тээвэрлэгчийн нэр хаягийг бүртгэж тэмдэглэнэ;

2.5.3. Цөмийн материалын дотоод тоо бүртгэлд өөрчлөлт орсон тухай бүр тайлбар бичгийн хамт дараа сарын 10-ны дотор ЦЭК-ын Ажлын алба болон мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад албан бичгээр мэдэгдэнэ;

2.5.4. Цөмийн материалтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага нь энэхүү журмын 1 дүгээр хавсралтад заагдсан Маягт 1, Маягт 2, Маягт 3-ыг ашиглан биет үзлэг тооллогын тайлан¹¹, материалын тэнцлийн тайлан¹² болон тооллогын өөрчлөлтийн тайлангуудыг¹³ жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор ЦЭК-ын Ажлын алба болон мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны

¹¹Биет тооллогын тайлан гэдэг нь цөмийн материалын тэнцлийн бүсэд бүртгэсэн цөмийн материалын бүх тоо хэмжээ, эсвэл тооцсон тоо хэмжээний нийлбэрийг хэлнэ.

Цөмийн материалын биет тооллого гэж цөмийн материалын тэнцлийн бүсэд тухайн журмын дагуу бүртгэсэн цөмийн материалын бүх тоо хэмжээ, эсвэл тооцсон тоо хэмжээний нийлбэрийг хэлнэ.

¹²Материалын тэнцлийн тайлан - Материалын тэнцлийн тайлангаар цөмийн материалын анхны бүртгэлд аливаа өөрчлөлт орсноор цөмийн материалын тэнцэл тодорхой хугацааны эцэст тэнцэж байхыг хэлнэ.

¹³Тооллогын өөрчлөлтийн тайлан - Цөмийн материалын бүртгэлд байгаа болон тооллогоор өөрчлөлт орсон аливаа өөрчлөлтийг хэлнэ. Энэ нь биет тооллого, тээвэрлэлт болон хэмжилтийн үр дүнгээр илэрхийлнэ.

байгууллагад хүргүүлнэ. Тайланг дагалдуулан нотолгоо болох баримтыг хавсаргана. (тээвэрлэлтийн бичиг баримтууд гэх мэт);

2.5.5. Материалын биет тооллогын¹⁴ дүнг үндэслэсэн тооллогын тайлан болон материалын тэнцлийн тайланг ЦЭК-ын Ажлын алба болон Мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад ажлын 20 хоногт багтаан илгээнэ. Үүнд:

а) тайлангийн мэдээлэлд нотолгоо болох баримтыг хавсаргана. (тээвэрлэлтийн бичиг баримтууд гэх мэт);

б) баталгааны тухай хэлэлцээрийн дагуу материалын өөрчлөлтийн тайланг тайлбар бичгийн хамт хүргүүлнэ;

в) хэрвээ материалын тэнцэлд¹⁵ бүртгэгдээгүй материал илэрвэл шалтгааныг тогтоож, ЦЭК-ын Ажлын алба болон мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад нэн даруй тайлагнана.

2.5.6. Цөмийн материалтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага нь дараах тохиолдолд ЦЭК-ын Ажлын алба болон мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад шуурхай мэдэгдэнэ:

а) цөмийн материалын биет тооллогын үед шилжилт хөдөлгөөний өөрчлөлт илэрсэн;

б) ослын үед цөмийн материалын шилжилт хөдөлгөөн гарсан, гарч болзошгүй, эсвэл гарах үндэслэлтэй сэжиг байгаа;

в) цөмийн материалыг хянах боломжид нөлөөлж болох осол гарсан, эсвэл гарч болох.

2.5.7. Цөмийн материалтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага нь цөмийн материалын байршлын мэдээлэл (үүнд байршлын газарзүйн мэдээлэл, газрын зураг дээрх тэмдэглэгээ, солбицлын цэг, талбай болон түүн дээрх барилга байгууламжийн зураг төсөл, тэдгээр байгууламжид ашигладаг төхөөрөмжийн техник үзүүлэлтүүд, ажиллах горим, тэдгээр байгууламж төхөөрөмжийг цөмийн материал боловсруулахад хэрхэн ашигладаг талаар тусгах)-ийг энэ журмын 2 дугаар хавсралтын Маягт 2-ыг ашиглан, өмнөх

¹⁴Цөмийн материалын тэнцлийн бүсэд тухайн журмын дагуу бүртгэсэн цөмийн материалын бүх тоо хэмжээ, эсвэл тооцсон тоо хэмжээний нийлбэр.

¹⁵Цөмийн материалын биет тооллоготой харьцуулсны үр дүнд бүртгэгдсэн цөмийн материал

хуанлийн жилд хамаарах мэдээллийг жил бүрийн 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор ЦЭК-ын Ажлын алба болон мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ. Мэдүүлгийн хуудсанд тухайн байршлын бүсийн газрын зургийг хавсаргана;

2.5.8. Цөмийн материалтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага нь хуанлийн жилийн төлөвлөсөн үйл ажиллагааны хөтөлбөрийг энэ журмын 2 дугаар хавсралтын Маягт 9-ийг ашиглан, жил бүрийн 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор ЦЭК-ын Ажлын алба болон мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ;

2.5.9. Цөмийн материалтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага нь хуанлийн жилийн дараагийн жилд төлөвлөсөн үйл ажиллагааны хөтөлбөрийг жил бүрийн 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор ЦЭК-ын Ажлын алба болон мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ;

2.5.10. Үндэсний хяналт шалгалтаар тайлагнавал зохих мэдээлэлд тухайлбал, ханган нийлүүлэгчийн техникийн баримт бичгүүдэд аливаа мэдээллийн зөрүү илэрвэл мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад даруй мэдэгдэж залруулга хийнэ;

2.5.11. ЦЭК-ын Ажлын алба болон мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тайлангаас бусад нэмэлт мэдээлэл болон түүнд холбогдох баримт бичгийг ирүүлэхийг шаардсан тохиолдолд тухай бүр нь тогтоосон хугацаанд багтаан хүргүүлнэ;

2.5.12. Цөмийн материалтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага нь Баталгааны тухай хэлэлцээрийн 42-44 дүгээр зүйлд заасан шаардлагын дагуу цөмийн материалтай холбоотой мэдээллийг ЦЭК-ын Ажлын албанд хүргүүлэх бөгөөд мэдүүлэгт дараах мэдээллийг тусгана:

- а) аж ахуйн нэгж, байгууллагын нэр болон хаяг;
- б) үйл ажиллагааны зорилго болон хэлбэр, ашиглаж буй технологи, хэрэглэж буй аюулгүй ажиллагааны болон бусад дүрмүүд;
- в) цөмийн материал, тэдгээрийн тоо хэмжээ, газар зүйн байршил, шилжилт хөдөлгөөний тухай мэдээлэл;
- г) цөмийн материалын бүртгэл, хяналтын тогтолцооны тухай мэдээлэл;



д) цөмийн материалтай холбоотой барилга байгууламжийн нарийвчилсан мэдээлэл, ашиглах төхөөрөмжийн технологийн үзүүлэлтүүд.

2.5.13. Энэ журмын 2.5.9-д заасан мэдээлэлтэй холбоотой өөрчлөлтийг нэн яаралтай бичгээр ЦЭК-ын Ажлын албанд хүргүүлнэ;

2.5.14. Цөмийн материалтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага нь тайлан мэдээллийн үнэн бодит байдалд хариуцлагатай хандана;

2.5.15. Дотоод бүртгэлд материалын тоо хэмжээг тодорхойлоход ашигласан хэмжилт хийх аргачлалууд (жинлэх, эзлэхүүнийг тодорхойлох, үл эвдэх сорил) нь үндэсний болон олон улсын хүлээн зөвшөөрсөн стандартын дагуу байна. Хэрэв хэмжилт хийж байгаа багажтай холбоотой хэмжилтийн стандарт нь дээрх шаардлагыг хангахгүй бол шинжлэх ухаан техникийн хамгийн сүүлийн үеийн шийдлийг харгалзан үзэх ба тус аргачлалыг ашиглахаас өмнө ЦЭК-ын Ажлын албанд албан ёсоор мэдэгдэнэ;

2.5.16. Цөмийн материалын бүртгэлийн тогтолцооны баримт бичгүүд болох тайлан тэдгээртэй холбоотой баримт мэдээллийг цөмийн материалтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага нь үйл ажиллагааг зогсоосноос хойш байгууллагынхаа архивд 5 жил хадгална;

2.5.17. Цөмийн материалтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага нь цөмийн материалын бүртгэлийг техникийн санамсаргүй тохиолдлоор устгах, алга болгох тохиолдолд цөмийн материалын бүртгэлтэй холбоотой асуудлаар ЦЭК-ын Ажлын алба болон мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас мэдээлэл авч болно.

Гурав. Урьдчилсан мэдэгдэл хүргүүлэх

3.1. Цөмийн материалыг экспортлохтой холбоотой урьдчилсан мэдэгдэл хүргүүлэх:

3.1.1. Энэ журмын 1 дүгээр хавсралтын Маягт 4-ийг ашиглан, нэг эффектив килограммаас¹⁶ хэтэрсэн цөмийн материал бүхий

¹⁶Баталгааны системд ашигладаг тусгай нэгж. Эффектив килограммын хэмжээг дараах байдлаар ойлгоно:

- а) плутонийн хувьд түүний жинг кг-аар;
- б) 0.01 (1%) буюу үүнээс их баяжилттай ураны хувьд түүний килограммаар илэрхийлэгдсэн жинг, баяжилтын квадратаар үржүүлсэн;

аливаа ачааг Монгол Улсын нутаг дэвсгэрээс гаргах бол энэ тухай ЦЭК-ын Ажлын алба болон мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад урьдчилсан мэдэгдэл хүргүүлнэ;

3.1.2. Энэ журмын 1 дүгээр хавсралтын Маягт 4-ийг ашиглан, нэг эффектив килограммаас илүү ачаа байхгүй хэдий ч аливаа дараалсан 3 сарын туршид нэг улсад гаргаж буй материалын нийт хэмжээ нь нэг эффектив килограммаас хэтрэхүйц байх төлөвтэй бол ЦЭК-ын Ажлын алба болон мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад урьдчилсан мэдэгдэл хүргүүлнэ;

3.1.3. Цөмийн материал экспортлох тухай урьдчилсан мэдэгдлийг ЦЭК-ын Ажлын алба болон мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад 21-ээс доошгүй хоногийн өмнө хүргүүлэх ба тухайн ачаанд хяналт, шалгалт хийх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

3.2. Цөмийн материалыг импортлохтой холбоотой урьдчилсан мэдэгдэл хүргүүлэх:

3.2.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт импортлохоор төлөвлөж буй цөмийн материалын хэмжээ нэг эффектив килограммаас хэтэрсэн тохиолдолд тухайн цөмийн материалын сав баглааг задлахаас 14-өөс доошгүй хоногийн өмнө ЦЭК-ын Ажлын алба болон мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад энэ журмын 1 дүгээр хавсралтын Маягт 5-ын дагуу урьдчилан мэдэгдэнэ;

3.2.2. Тухайн нэг ачааны хувьд нэг эффектив килограммаас хэтрээгүй боловч аливаа дараалсан 3 сарын хугацаанд нэг улсаас импортлохоор төлөвлөж буй цөмийн материалын нийт хэмжээ нь нэг эффектив килограммаас хэтэрсэн цөмийн материалыг Монгол Улсын нутаг дэвсгэрт хүлээн авсан тухай урьдчилсан мэдэгдлийг тухайн цөмийн материалын сав баглааг эхлэн задлахаас 14-өөс доошгүй хоногийн өмнө энэ журмын 1 дүгээр хавсралтын Маягт 5-ыг ашиглан, ЦЭК-ын Ажлын алба болон мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ. Бусад ачаануудын хувьд эхний ачааны мэдэгдлийг хүргүүлэх үедээ тусгах, эсвэл ачаа бүрийг тухайн цөмийн материалын сав баглааг задлахаас өмнө тусгайлан мэдэгдэнэ;

в) 0.01 (1%-оос бага болон 0.005 (0,5%)-аас их баяжилттай ураны хувьд түүний килограммаар илэрхийлэгдсэн жинг 0.0001-ээр үржүүлсэн;

г) 0.005 (0,5%)-ын эсвэл, үүнээс бага баяжилттай ядууруулсан уран ба торийн хувьд түүний килограммаар илэрхийлэгдсэн жинг 0.00005-аар үржүүлсэн.

3.2.3. Мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь урьдчилсан мэдэгдэлд заасан сав баглаа задлахаас 5 хоногоос доошгүй хугацааны өмнө хяналт, шалгалт хийнэ;

3.2.4. Цөмийн материалын бүртгэл тооллогын холбогдох үүргийг хэрэгжүүлэхэд хангалттай хэмжээний нотолгоо¹⁷, мэдээллийг ирүүлээгүй тохиолдолд Монгол Улсын нутаг дэвсгэр лүү тээвэрлэхийг хориглоно;

3.2.5. Цөмийн материал эзэмшигч байгууллага нь нэг эффектив килограммаас дээш хэмжээтэй цөмийн материал бүхий ачааг хүлээн авах тохиолдолд ханган нийлүүлэгчээс тухайн ачааг хүлээн авахаас 1-ээс доошгүй сарын өмнө ачааг дагалдах баримт бичиг болон холбогдох мэдээллийг авсан байна. Цөмийн материал эзэмшигч байгууллага нь тухайн мэдээллийг хүлээн авмагц ЦЭК-ын Ажлын алба болон мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

Дөрөв. Мэдээлэл хүргүүлэхтэй холбоотой үүрэг хариуцлага

4. Шинээр цөмийн байгууламж¹⁸ барих талаар гарсан шийдвэрийг хэрэгжүүлэгч мөн цөмийн материалтай холбоотой үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг:

4.1. Цөмийн байгууламж барихтай холбоотой урьдчилсан мэдээллүүд болон тэдгээрийн зураг төлөвлөлтийн тухай мэдээллийг дор дурдсан үе шат бүрд ЦЭК-ын Ажлын албанд хүргүүлнэ:

а) цөмийн төхөөрөмж барих шийдвэр гаргасан үед, эсвэл барих тусгай зөвшөөрөл олгогдсон үед;

б) цөмийн төхөөрөмж барих тухай тусгай зөвшөөрөлд өөрчлөлт оруулах тухай өргөдөл гаргах үед болон суурилуулах тухай тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргах үед;

в) цөмийн төхөөрөмж барих тусгай зөвшөөрлийг шинэчлэхтэй холбоотой өргөдөл гаргах үед.

¹⁷Импортолж байгаа цөмийн материалын эцсийн хэрэглэгч нь тухайн материалыг аюулгүй ашиглах удирдлагын болон техникийн чадавх болон хангалттай нөөц бололцоотойгоо нотолсон мэдээллийг хэлнэ.

¹⁸а) цөмийн реактор, критик байгууламж, боловсруулах, хувиргах, дахин боловсруулах, изотоп салгах үйлдвэр, эсвэл ангилан хадгалах төхөөрөмж;

б) нэг эффектив килограммаас дээш хэмжээгээр цөмийн материал ашигладаг аливаа байгууламж;

4.1.1. Цөмийн материалтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага нь цөмийн байгууламж болон түүнтэй холбоотой мэдээллийг ЦЭК-ын Ажлын албанд цөмийн материалыг хүлээн авахаас 7-оос доошгүй сарын өмнө хүргүүлэх бөгөөд хүргүүлсэн мэдээлэлд орсон аливаа өөрчлөлтийг даруй мэдэгдэнэ.

4.1.2. Цөмийн материалтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага нь нэмэлт протоколын 2 дугаар хавсралтад заасан цөмийн бус материал, эсвэл тоног төхөөрөмжийг Монгол Улсын нутаг дэвсгэрээс экспортлохдоо ачуулсан тоног төхөөрөмж болон материалын талаарх тайланг улирал тутам энэ журмын 2 дугаар хавсралтын Маягт 8-ын дагуу улирал бүрийн сүүлчийн өдрөөс хойш 30 хоногийн дотор ЦЭК-ын Ажлын алба болон мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ;

4.1.3. Цөмийн материалтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага нь нэмэлт протоколын 2 дугаар хавсралтад заасан цөмийн бус материал, тоног төхөөрөмжийг Монгол Улсын нутаг дэвсгэрийн гаднаас импортлоход хүлээн авсан тоног төхөөрөмж болон материалын талаарх тайланг энэ журмын 2 дугаар хавсралтын Маягт 8-ын дагуу хүлээн авсны дараа 30 хоногийн дотор ЦЭК-ын Ажлын алба болон мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

4.2. Уран олборлох, боловсруулах үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг:

4.2.1. Цөмийн материал (эх үүсвэр материал болон хуваагдах тусгай материал)¹⁹ эзэмшиж байгаа иргэн, хуулийн этгээд нь химийн найрлага болон цэвэршлээрээ түлш үйлдвэрлэх, эсвэл изотоп баяжуулахад боломжгүй бол түүнийг үндэслэл болгон, Монгол Улсын нутаг дэвсгэрт хүлээн авсан болон Монгол Улсын нутаг дэвсгэрээс гаргахаар ачуулсан цөмийн материалын тоо хэмжээ, материалын нөөцийг энэ журмын 2 дугаар хавсралтын Маягт 5-ын дагуу гарган, жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор ЦЭК-ын Ажлын алба болон мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ;

¹⁹Цөмийн материал нь ОУАЭА-ийн дүрмийн ХХ зүйлд тодорхойлолтын дагуу эх үүсвэр материал болон аливаа цөмийн хуваагдлын тусгай материалыг хэлнэ.

-Эх үүсвэр материал нь байгалийн уран, эсвэл байгальд орших изотопуудын холимгийг агуулсан уран, уран-235 изотопоор ядуурсан уран, тори тэдгээрийн аливаа төрлийн металл, хайлш, химийн нэгдэл, баяжмал хэлбэрээр байх дээр дурдсан материалын аль ч байж болно. Эх үүсвэр материалд хүдэр, хүдрийн хаягдал хамаарахгүй.

-Хуваагдах цөмийн тусгай материал нь байгаль дээр оршдоггүй бөгөөд эх үүсвэр материалаас гаргаж авна. Уран-233, плутони-239, уран-235 болон уран-233 изотопоор баяжуулсан уран нь хуваагдах цөмийн тусгай материалд орно.

4.2.2. Ураны хайгуул, олборлолт, ураны хүдэр баяжуулах, тори баяжуулах байгууламж болон хаагдсан ураны уурхайн ашиглалтыг хууль ёсоор залгамжилж, үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллага нь энэ журмын 2 дугаар хавсралтын Маягт 4-ийг ашиглан, үйл ажиллагааныхаа тухайн жилийн тайланг мэдүүлнэ. Маягтын дагуу тайланг жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор ЦЭК-ын Ажлын алба болон мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ;

4.2.3. Цөмийн материалтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага нь Баталгааны тухай хэлэлцээрийн 11 дүгээр зүйлийн дагуу баталгаанд хамрагдах хугацаа нь дуусгавар болсон плутони, өндөр баяжуулсан уран, эсвэл уран-233 агуулсан дунд болон өндөр идэвхтэй цацраг идэвхт хаягдлын байршил болон цаашдын боловсруулалтад хамаарах мэдээллийг энэ журмын 2 дугаар хавсралтын Маягт 7-ийн дагуу ЦЭК-ын Ажлын албанд хүргүүлнэ. Энэ маягтыг ашиглан, цаашдын боловсруулалт эхлэхээс 7 сарын өмнө ЦЭК-ын Ажлын алба болон мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад урьдчилан хүргүүлнэ.

4.3. Цөмийн түлшний циклд эрдэм шинжилгээ болон туршилт-зохион бүтээх ажиллагаа явуулах аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг:

4.3.1. Цөмийн материалтай холбоогүй боловч цөмийн түлшний циклд эрдэм шинжилгээ, судалгаа хийх, зохион бүтээх ажиллагаа явуулах эсвэл Нэмэлт протоколын 1 дүгээр хавсралтад дурдсан аливаа үйл ажиллагаа явуулах иргэн хуулийн этгээд нь энэ журмын 2 дугаар хавсралтын Маягт 1 ба Маягт 3-ыг ашиглан, мэдүүлгээ жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор ЦЭК-ын Ажлын алба болон мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ;

4.3.2. Цөмийн түлшний цикл (цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа мөн хамаарна)-д үйлдвэрлэл, ашиглалт үйл ажиллагааны ирэх 10 жилийн ерөнхий төлөвлөгөөний тухай мэдээллийг энэ журмын 2 дугаар хавсралтын Маягт 9-ийн дагуу тайланг, жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор ЦЭК-ын Ажлын албанд хүргүүлнэ.

Тав. Хяналт

5.1. ЦЭК-ын Ажлын албанаас хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

5.1.1. Цөмийн материалын хяналттай холбоотой үүрэг хариуцлагыг олон улсын гэрээнд нийцүүлэн хэрэгжүүлж, цөмийн

материалыг иж бүрэн хяналтад байлгах нөхцөлийг хангана. Үр дүнтэй баталгааны тогтолцоог бий болгож, хяналтын тогтолцоонд тулгуурлан иж бүрэн хяналтыг хэрэгжүүлнэ;

5.1.2. Монгол Улсын хүлээсэн үүрэг хариуцлагын дагуу олон улсын гэрээний хэрэгжилтийг хангуулахын тулд шаардлагатай бүх арга хэмжээг хэрэгжүүлж, холбогдох мэдээллийг ОУАЭА-д хүргүүлэн ОУАЭА-ийн хяналт, шалгалтад дэмжлэг үзүүлж, бодит мэдээллээр хангах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ;

5.1.3. ОУАЭА-аас хийгдэх хяналт шалгалтын²⁰ ажилд дэмжлэг үзүүлж, баталгааны шинжээчдийг²¹ саадгүй нэвтрүүлэх үйл ажиллагааг шуурхай зохион байгуулан олон улсын хяналтад хамрагдаж буй байгууллага хооронд мэдээллийг шуурхай дамжуулж, хяналт шалгалтын бэлэн байдлыг хангуулна;

5.1.4. ОУАЭА-аас хийгдэх хяналт шалгалтын тухай мэдээллийг авсан даруй мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон хяналтад хамрагдах байгууллагад хяналт шалгалтын тухай мэдээллийг хүргүүлж, бэлэн байдлыг хангуулна;

5.1.5. Нэмэлт протоколын 11 дүгээр зүйлийн а.(i)-д заасны дагуу ОУАЭА-ийн шинжээч нарыг томилох тухай заасны дагуу томилогдсон шинжээчдийн бүрэлдэхүүний мэдээллийг ОУАЭА-аас хүлээн авснаас хойш 3 сарын дотор шинжээчдийн бүрэлдэхүүнийг Монгол Улс хүлээн зөвшөөрөх эсэхээ мэдэгдэнэ. Мэдэгдээгүй тохиолдолд уг бүрэлдэхүүнийг зөвшөөрсөнд тооцож томилно.

5.2. Мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

5.2.1. Энэхүү журмаар Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа цөмийн материал эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллага, мөн тэдгээрийн байршилд Баталгааны тухай хэлэлцээр болон Нэмэлт протоколоор Монгол Улсын хүлээх үүргийн дагуу тайлагнасан цөмийн материалын тайланг магадлан шалгах зорилготой хяналт шалгалтыг хэрэгжүүлнэ;

²⁰Нэмэлт протоколын хүрээнд Монгол Улсын илгээсэн мэдээллийн үнэн зөв хийгээд бүрэн гүйцэд гэдгийг тогтоон шалгах, эсхүл энэ мэдээлэлтэй холбогдсон алдаа зөрчлийг арилгах зорилгоор хийж буй хяналт шалгалтыг хэлнэ.

²¹ОУАЭА-ийн Ерөнхий захирлуудын зөвлөлөөс томилогдсон шинжээчид болон тэдгээрийн бүрэлдэхүүн

5.2.2. Баталгааны үр дүнтэй тогтолцоог бий болгож, хяналтыг хэрэгжүүлэхийн тулд хяналтын тогтолцооны дараах хэрэгслүүдийг ашиглана:

а) цөмийн материал эзэмшигч байгууллагын хэрэгжүүлж буй баталгааны арга хэмжээ нь хяналтын ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэхэд тавигдах зохих шаардлагуудыг хангах;

б) үүрэг хариуцлагын дагуу ирүүлсэн тайлан болон тэдгээрт үнэлгээ хийснээр цөмийн материалтай холбоотой үйл ажиллагаанд хяналт тавих;

в) мэдээлэх үүрэг хариуцлагын дагуу олж авсан мэдээлэл болон хязгаарлалт, тандалтын системийн ашиглалт, байршилд хийх хяналт шалгалтын явц, баталгааны арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлж байгаа эсэхийг бодит байдлаар хянан магадлах.

5.2.3. ОУАЭА-ийн хяналт, шалгалтад хамтран оролцох бөгөөд тус ОУАЭА-ийн шинжээчдийг ирэх хүртэл хяналт шалгалтыг эхлүүлж болохгүй;

5.2.4. ОУАЭА-ийн хяналт шалгалтын үед хяналтад хамрагдаж буй байгууллагын ажилтанд аливаа зааварчилгаа өгөхгүй ба байгууламжид хамаарах багаж төхөөрөмжтэй харьцаж болохгүй;

5.2.5. Эрх бүхий байгууллагаас хянан шалгах явцад шалгалтын зорилгоо биелүүлэхийн тулд байгууллагын зүгээс тодорхой үйлдэл, арга хэмжээ авах шаардлагатай гэж шинжээч үзвэл байгууламжийн аюулгүй ажиллагааг харгалзан, энэ тухай зөвлөмж боловсруулж, эрх бүхий этгээдэд танилцуулан, зохих шийдвэр гаргуулна;

5.2.6. ОУАЭА-ийн шинжээчид хяналт хийхэд холбогдох бүртгэл, тэмдэглэлийг хөтөлнө. Бүртгэлд хяналт хийсэн байршил, хугацаа, хамтран оролцсон хүний нэр, хяналтын үр дүн, илэрсэн зөрчил дутагдал болон зөрчлийг арилгуулах арга хэмжээ зэргийг тусгана. Хяналтын тэмдэглэл нь шалгуулж буй байгууллагын ашиглалтын бүртгэлийн нэг хэсэг болох бөгөөд хяналтын тэмдэглэлийн хуулбарыг ЦЭК-ын Ажлын албанд даруй хүргүүлнэ.

5.3. Баталгааны тухай хэлэлцээрийн дагуу баталгаанд хамрагдахаас чөлөөлөгдөх:

5.3.1. Цөмийн материалтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага нь баталгааны тухай хэлэлцээрийн

35, 36 дугаар зүйлд зааснаар тухайн цөмийн материал нь ОУАЭА-ийн баталгааны хяналтаас чөлөөлөгдөх²² бол уг цөмийн материалыг чөлөөлүүлэх хүсэлтээ ЦЭК-ын Ажлын алба болон мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад даруй бичгээр мэдэгдэнэ;

5.3.2. Баталгаанд хамрагдахаас чөлөөлөгдсөн цөмийн материалын мэдээллийг дотоод тоо бүртгэл болон төвлөрсөн тоо бүртгэлд тусгана;

5.3.3. Цөмийн материалтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага нь олон улсын баталгаанаас чөлөөлөх цөмийн материалын тайланг энэ журмын 2 дугаар хавсралтын Маягт 6-г ашиглан, жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор ЦЭК-ын Ажлын алба болон Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

5.4. ОУАЭА-ийн хяналт, шалгалт:

5.4.1. Баталгааны тухай хэлэлцээрийн 47 болон 69-83 дугаар заалт, нэмэлт протоколын 4-9 дүгээр заалтын дагуу олон улсын хяналт шалгалт явуулах эрх үүргийн хүрээнд шаардлагатай тохиолдолд Монгол Улсын хүлээсэн үүргийн хэрэгжилтийг магадлан шалгах зорилгоор ОУАЭА-ийн шинжээчид цөмийн материалтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллага, тэдгээрийн байршилд хяналт шалгалт хийнэ;

5.4.2. ОУАЭА нь Баталгааны тухай хэлэлцээрийн 9 ба 85 дугаар зүйл, Нэмэлт протоколын 11 дүгээр зүйлд заасны дагуу Монгол Улсын хүлээн зөвшөөрсөн баталгааны шинжээчийг томилж, байршлын бүсэд олон улсын хяналт явуулна;

5.4.3. ОУАЭА-аас хяналт шалгалт хийх тухайгаа Монгол Улсад 24 цагаас багагүй хугацааны өмнө мэдэгдэнэ. Нэмэлт протоколын хүрээнд мэдүүлсэн мэдээллийг шалгахтай холбоотой хийх хяналт шалгалтын хувьд урьдчилан мэдэгдэх хугацаа нь 2 цаг байх бөгөөд онцгой нөхцөл байдалд 2 цагаас доошгүй байна;

5.4.4. Байршилд хяналт явуулах ОУАЭА-ийн шинжээч нар дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

²²Баталгааны гэрээний 35, 36 дугаар зүйлийн дагуу баталгаанд хамрагдахаас чөлөөлөгдөх цөмийн материалын тоо хэмжээ, ашиглалтын төрөл болон байршил.

а) хяналтын зорилгыг хэрэгжүүлэхийн тулд аман болон бичгээр мэдээлэл авах, нүдэн ажиглалт хийх, хүрээлэн байгаа орчны дээж авах²³, хэмжих багаж ашиглах, баримт бичгийг хувилах, дуу болон дүрс бичлэг хийх, гэрэл зураг авах, тандалтын багаж төхөөрөмж суурилуулах;

б) энэ зүйлийн а)-д заасан үйл ажиллагаанд хэмжилтийн багаж хэрэгсэл ашиглах;

в) цөмийн материалыг хууль бус хөдөлгөөн, хорлон сүйтгэх үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх зорилгоор ОУАЭА-ийн шинжээчид тандалтын төхөөрөмж суурилуулах, дүрс, бичлэг хийх зэргээр хязгаарлалтын арга хэмжээ авах зориулалтаар багаж төхөөрөмж суурилуулах (суурилуулсан тандалтын төхөөрөмж, хэрэгслүүд нь хяналтыг үр дүнтэй явуулах, байнгын хяналт хийх зорилготой байна).

5.5. Хяналт шалгалтад хамрагдаж буй байгууллагаас хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

5.5.1. Хяналт шалгалтад хамрагдаж буй байгууллага нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

а) хяналт хийх байгууламжид баталгааны шинжээчдийг саадгүй нэвтрүүлэх;

б) хяналт шалгалтад хамрагдаж буй цөмийн материалтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага нь шинжээчдэд цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагаа болон ослоос урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах дүрэм, журмын тухай ерөнхий мэдээллийг өгөх;

в) баталгааны мэргэжилтэн буюу түүнийг орлон гүйцэтгэгч хяналт шалгалт явуулахад оролцож, хяналт шалгалтын хэрэгжилтийг баталгаажуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд арга хэмжээ авч, хэрэгжүүлэх эрх бүхий мэргэжилтэнг оролцуулах.

5.5.2. ОУАЭА-аас хяналт шалгалт хийх тухайгаа цөмийн материалтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагад шууд мэдэгдсэн тохиолдолд байгууллага нь хяналт шалгалтын тухай мэдээллийг ЦЭК-ын Ажлын алба болон мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад даруй мэдэгдэж, хяналт шалгалтын бэлэн байдлыг хангана;

²³цөмийн материалын гарал үүсэл, байршилд хамаарах хүрээлэн буй орчноос дээж авах (агаар, ус, ургамал, хөрс, арчдас).



5.5.3. ОУАЭА нь хяналт шалгалтын холбогдох бүртгэл, тэмдэглэлийг хөтөлнө. Бүртгэлд хяналт хийсэн байршил, хугацаа, хамтран оролцсон хүний нэр, хяналтын үр дүн, илэрсэн зөрчил дутагдал болон зөрчлийг арилгуулах арга хэмжээ зэргийг тусгана. Хяналтын тэмдэглэл нь шалгуулж буй байгууллагын ашиглалтын бүртгэлийн нэг хэсэг болох бөгөөд хяналтын тэмдэглэлийн хуулбарыг ЦЭК-ын Ажлын алба болон Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

Хавсралт 1

ЦӨМИЙН МАТЕРИАЛЫН БҮРТГЭЛ, ТООЛЛОГЫН ТАЙЛАНГИЙН МАЯГТУУД

| Маягт № | Маягтын нэр |
|---------|---|
| Маягт 1 | Биет үзлэг тооллогын тайлан |
| Маягт 2 | Материалын тэнцлийн тайлан |
| Маягт 3 | Тооллогын өөрчлөлтийн тайлан |
| Маягт 4 | Монгол Улсаас экспортод гаргахаар төлөвлөж буй цөмийн материалыг урьдчилан мэдэгдэх маягт |
| Маягт 5 | Монгол Улсад цөмийн материал импортлохоор төлөвлөж буй цөмийн материалыг урьдчилан мэдэгдэх маягт |

Хавсралт 2

ЦӨМИЙН ЗЭВСГИЙГ ҮЛ ДЭЛГЭРҮҮЛЭХ ГЭРЭЭТЭЙ ХОЛБОГДУУЛАН БАТАЛГАА ХЭРЭГЛЭХ ТУХАЙ МОНГОЛ УЛС, ОУАЭА-ИЙН ХООРОНД БАЙГУУСАН ХЭЛЭЛЦЭЭРИЙН НЭМЭЛТ ПРОТОКОЛЫН МЭДҮҮЛГҮҮД

| Маягт № | Нэмэлт протоколын мэдүүлэг № | Нэмэлт протоколын мэдүүлгийн агуулга |
|---------|------------------------------|---|
| Маягт 1 | 2.а (i) | Цөмийн материалтай холбоогүй боловч цөмийн түлшний циклд эрдэм шинжилгээ, судалгаа хийх, зохион бүтээх ажиллагааны тухай мэдээлэл |
| Маягт 2 | 2.а (iii) | Байршлын ерөнхий тодорхойлолт болон мэдээлэл (байршил бүрд байгаа барилгын ерөнхий тодорхойлолт, ашиглалтын чиглэл, байршлын газарзүйн зураг) |



| | | |
|---------|------------|--|
| Маягт 3 | 2.a (iv) | Нэмэлт протоколын 1 дүгээр хавсралтад дурдсан үйл ажиллагаанд хамаарах байршил бүрд хамаарах үйл ажиллагааны цар хүрээний тодорхойлолт |
| Маягт 4 | 2.a (v) | Ураны хайгуул, олборлолт, боловсруулах үйлдвэр, торийн боловсруулах үйлдвэрийн жилийн урьдчилан тооцсон бүтээгдэхүүн үйлдвэрлэл, ашиглалтын байдал, байршлын мэдээлэл, тэдгээр уурхай болон баяжуулах үйлдвэрийн жилийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл (одоогийн) |
| Маягт 5 | 2.a (vi) | Түлшний үйлдвэрлэл, эсвэл изотопоор баяжуулахад цэвэршилт болон найрлагын хувьд шаардлага хангахгүй эх үүсвэр материалын мэдээлэл |
| Маягт 6 | 2.a (vii) | Баталгаанд хамрагдахаас чөлөөлөгдөх цөмийн материалын ашиглалтын төрөл болон байршил |
| Маягт 7 | 2.a (viii) | Баталгаанд хамрагдах хугацаа нь дуусгавар болсон плутони, өндөр баяжуулсан уран, эсвэл уран-233 агуулсан дунд, эсвэл өндөр зэрэглэлийн идэвх бүхий хаягдлын байршил болон цаашдын боловсруулалтад хамаарах мэдээлэл |
| Маягт 8 | 2.a (ix) | Нэмэлт протоколын 2 дугаар хавсралтад дурдсан цөмийн бус материалд хамаарах мэдээлэл болон багаж төхөөрөмжийн экспорт, эсвэл импорттой холбоотой мэдээлэл |
| Маягт 9 | 2.a (x) | Цөмийн түлшний циклд хамаарах эрдэм шинжилгээ, судалгаа хийх, зохион бүтээх ажиллагаатай холбоотой дараагийн 10 жилийн ерөнхий төлөвлөгөө |



Маягт 2

Материалын тэнцлийн тайлан (МТТ)

| | | | | | | | | | |
|--|----------------|----------------------|----------------------|--|--------|---------|---------|------------------|------------|
| Улс: Тайланд хамрах хугацаа: (огноо) Байгууламж: зэс хүртэл Материалын тэнцлийн бүс: Хуудасны дугаар:....., нийт.....хуудастай Тайлангийн №:.....Гарын үсэг..... | | | | | | | | | |
| № | Материалын нэр | Тоо бүртгэлийн огноо | | | | | | Загруулга хийсэн | |
| | | Элемент | Элементийн масс (гр) | Хуваагдах изотопын агуулгын масс (зөвхөн ураны хувьд) (гр) | Изотоп | Элемент | Тайлбар | Тайлангийн № | Мөрийн тоо |
| | | | | | | | | | |
| | | | | | | | | | |
| | | | | | | | | | |



Маягт 4

МОНГОЛ УЛСААС ЭКСПОРТОД ГАРГАХААР ТӨЛӨВЛӨЖ БУЙ
ЦӨМИЙН МАТЕРИАЛЫГ УРЬДЧИЛАН МЭДЭГДЭХ МАЯГТ

Огноо:

Монгол Улсаас экспортлохоор төлөвлөж байгаа ОУАЗА-ийн баталгаанд хамаарах дараахь үзүүлэлттэй цөмийн материалыг бид үүгээр урьдчилан мэдэгдэж байна:

| | | |
|-----|--|---------------------|
| № | Цөмийн материалтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагын бүтэн нэр, түүний мэдээлэл (хаяг, утас, цахим шуудангийн хаяг) | |
| 1. | Бүтээгдэхүүний нэр | |
| 2. | Тээвэрлэхээр тооцоолсон огноо | |
| 3. | Багц /хүргэлтийн дугаар/ огноо | |
| 4. | Ачаан дахь барааны тоо | |
| 5. | Ачаан дахь барааны төрөл тодорхойлолт | |
| 6. | Ачаа/Багцын тайлбар: | |
| 7. | Материалын жин | гр/кг элемент: |
| | | гр хуваагдах изотоп |
| 8. | Химийн найрлага: | |
| 9. | Физик төлөв: | |
| 10. | Баяжуулалт, эсвэл изотопын найрлага: | |
| 11. | Эцсийн хүрэх газар ба улс: | |
| 12. | Дамжин өнгөрөх улс: | |
| 13. | Тээврийн хэрэгсэл: | |
| 14. | Тээврийн хяналтын өмнөх ачааны байршил: | |
| 15. | Хяналт, шалгалтын огноо: | |
| 16. | Урьдчилан тооцоноор ачаа ирэх огноо ба хугацаа: | |
| 17. | Тээвэрлэлтийн эцсийн цэгт хүрэх хугацаа ба урьдчилан тооцсон огноо: | |
| 18. | Тээвэрлэлтийн эцсийн цэг: | |

.....

Гарын үсэг

.....

Огноо

Тайлбар: Хэрэв нэг улсад хүргэх нэг удаагийн ачилт нь хэд хэдэн ачаанаас бүрдсэн бол нэгдсэн мэдээгдлийн маягаар бүх ачаанд илгээнэ.



Маягт 5

МОНГОЛ УЛСАД ЦӨМИЙН МАТЕРИАЛ ИМПОРТЛОХООР ТӨЛӨВЛӨЖ
БУЙ ЦӨМИЙН МАТЕРИАЛЫГ УРЬДЧИЛАН МЭДЭГДЭХ МАЯГТ

Огноо:

Монгол Улсад импортлохоор төлөвлөж байгаа болон ОУАЭА-ийн баталгаанд хамаарах дараах шилжүүлгийн үзүүлэлттэй цөмийн материалыг бид үүгээр урьдчилан мэдэгдэж байна:

| | | |
|-----|---|---------------------|
| № | Цөмийн материалтай холбоотой үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагын бүтэн нэр, түүний мэдээлэл (хаяг, утас, цахим шуудангийн хаяг) | |
| 1. | Бүтээгдэхүүний нэр | |
| 2. | Тээвэрлэхээр тооцоолсон огноо | |
| 3. | Багц /хүргэлтийн дугаар/ огноо | |
| 4. | Ачаан дахь барааны тоо | |
| 5. | Ачаан дахь барааны төрөл тодорхойлолт (битүүмжлэлийн холбогдох үзүүлэлтийг оролцуулан): | |
| 6. | Ачаа/Багцын тайлбар: | |
| 7. | Материалын жин | гр/кг элемент: |
| 8. | | гр хуваагдах изотоп |
| 9. | Химийн найрлага: | |
| 10. | Физик төлөв: | |
| 11. | Баяжуулалт, эсвэл изотопын найрлага: | |
| 12. | Экспортолж буй улс: | |
| 13. | Дамжин өнгөрөх улс : | |
| 14. | Тээврийн хэрэгсэл: | |
| 15. | Ачааг хүлээн авах байршил болон ачааны сав баглааг задлахын өмнө шалгах боломжтой байршил | |
| 16. | Хяналт, шалгалтын огноо: | |
| 17. | Урьдчилан тооцооноор ачаа ирэх огноо ба хугацаа: | |
| 18. | Монгол Улсын ачаа хүлээн авах эцсийн цэг: | |

.....
Гарын үсэг

Огноо
.....



**ХАВСРАЛТ 2. ЦӨМИЙН ЗЭВСГИЙГ ҮЛ ДЭЛГЭРҮҮЛЭХ ГЭРЭЭТЭЙ
ХОЛБОГДУУЛАН БАТАЛГАА ХЭРЭГЛЭХ ТУХАЙ МОНГОЛ УЛС,
ОУАЗА-ИЙН ХООРОНД БАЙГУУЛСАН ХЭЛЭЛЦЭЭРИЙН
НЭМЭЛТ ПРОТОКОЛЫН МЭДҮҮЛГҮҮД**

Маягт 1

Цөмийн материалтай холбоогүй боловч цөмийн түлшний циклд эрдэм шинжилгээ, судалгаа хийх, зохион бүтээх ажиллагааны тухай мэдээлэл

| Нэмэлт протоколын 2.а (i) мэдүүлэг | | | | | |
|---|--------------------|----------------------------------|-------------------------------|---|---------|
| Мэдүүлгийн №: | | | | | |
| Мэдүүлгийн огноо (өдөр/сар/жил): | | | | | |
| Хамрах хугацаа (өдөр/сар/жил-өдөр/сар/жил): | | | | | |
| № | Тайлбар, лавлах | Цөмийн түлшний циклийн үе шат | Үйл ажиллагааны байршил | Үйл ажиллагааны ерөнхий тодорхойлолт | Тайлбар |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |



Маягт 2

Байршлын ерөнхий тодорхойлолт болон мэдээлэл-(байршил бүрд байгаа барилгын ерөнхий тодорхойлолт, ашиглалтын чиглэл, байршлын газарзүйн зураг)

| Нэмэлт протоколын 2.а (iii) мэдүүлэг | | | | | |
|--|-----------------|--------------------------|---------------------|----------------------|---------|
| Байршлын газарзүйн солбицлын цэг: | | | | | |
| Хавсаргасан газрын зургийн тодорхойлолт (цаасан болон цахим хэлбэрээр-Файлын нэр): | | | | | |
| Мэдүүлгийн №: | | | | | |
| Мэдүүлгийн огноо (өдөр/сар/жил): | | | | | |
| Хамрах хугацаа (өдөр/сар/жил-өдөр/сар/жил): | | | | | |
| № | Тайлбар, лавлах | Байгууламж, байршлын код | Барилга, байгууламж | Ерөнхий тодорхойлолт | Тайлбар |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |



Маягт 3

Нэмэлт протоколын 1 дүгээр хавсралтад дурдсан үйл ажиллагаанд хамаарах байршил бүрд хамаарах үйл ажиллагааны цар хүрээний тодорхойлолт

| Нэмэлт протоколын 2.а (iv) мэдүүлэг | | | | | |
|---|-----------------|-------------------|-------------------------|---------------------------|---------|
| Мэдүүлгийн №: | | | | | |
| Мэдүүлгийн огноо (өдөр/сар/жил): | | | | | |
| Хамрах хугацаа (өдөр/сар/жил-өдөр/сар/жил): | | | | | |
| № | Тайлбар, лавлах | Хавсралт, ангилал | Үйл ажиллагааны байршил | Үйл ажиллагааны цар хүрээ | Тайлбар |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |



Ураны хайгуул, олборлолт, боловсруулах үйлдвэр, торийн боловсруулах үйлдвэрийн жилийн урьдчилан тооцсон бүтээгдэхүүн үйлдвэрлэл, ашиглалтын байдал, байршлын мэдээлэл, тэдгээр уурхай болон боловсруулах үйлдвэрийн жилийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл (одоогийн)

| Нэмэлт протоколын 2.а (v) мэдүүлэг | | | | | | |
|---|-----------------|------------------|-------------------------|---------|---|---------|
| Мэдүүлгийн №: | | | | | | |
| Мэдүүлгийн огноо (өдөр/сар/жил): | | | | | | |
| Хамрах хугацаа (өдөр/сар/жил–өдөр/сар/жил): | | | | | | |
| № | Тайлбар, лавлах | Ашиглалтын төрөл | Ашиглалтын төлөв байдал | Байршил | Урьдчилан тооцсоноор жилийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл (тонн уран эсвэл тонн тори) | Тайлбар |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |



Маягт 5

Түлшний үйлдвэрлэл, эсвэл изотопоор баяжуулахад цэвэршилт болон найрлагын хувьд шаардлага хангахгүй эх үүсвэр материалын мэдээлэл

| Нэмэлт протоколын 2.а (vi) мэдүүлэг | | | | | | | |
|--|-----------------|----------------------------|-----------------------|--|--|-----------------|---------|
| Мэдүүлгийн №: | | | | | | | |
| Мэдүүлгийн огноо (өдөр/сар/жил): | | | | | | | |
| Хамрах хугацаа (өдөр/сар/жил–өдөр/сар/жил): | | | | | | | |
| а) Мэдүүлгийн хамрах хүрээний сүүлийн өдрийн байдлаар тэдгээр материалын ашиглалт, төлөвлөсөн ашиглалт, химийн найрлага болон тоо хэмжээ | | | | | | | |
| № | Тайлбар, лавлах | Байршил | Химийн найрлага | Тоо хэмжээ (тонн уран эсвэл тонн тори) | Ашиглахаар төлөвлөсөн | | Тайлбар |
| | | | | | Код | Ашиглалт | |
| | | | | | | | |
| | | | | | | | |
| | | | | | | | |
| | | | | | | | |
| б) Эх үүсвэр материалын экспорт | | | | | | | |
| № | Тайлбар, лавлах | Эцсийн хүрэх газар (улс) | Завсрын хүрэх газрууд | Химийн найрлага | Тоо хэмжээ (тонн уран эсвэл тонн тори) | Экспортын огноо | Тайлбар |
| | | | | | | | |
| | | | | | | | |
| | | | | | | | |
| | | | | | | | |
| в) Эх үүсвэр материалын импорт | | | | | | | |
| № | Тайлбар, лавлах | Эцсийн хэрэглээний байршил | Химийн найрлага | Тоо хэмжээ (тонн уран эсвэл тонн тори) | Төлөвлөсөн эцсийн хэрэглээ | Импортын огноо | Тайлбар |
| | | | | | | | |
| | | | | | | | |
| | | | | | | | |



Маягт 6

Баталгаанд хамрагдахаас чөлөөлөгдөх цөмийн материалын ашиглалтын төрөл болон байршил

| Нэмэлт протоколын 2.а (vii)-мэдүүлэг | | | | | | | | |
|---|-----------------|---------|--|----------|-----------------------|---------------------|----------|---------|
| Мэдүүлгийн №: | | | | | | | | |
| Мэдүүлгийн огноо (өдөр/сар/жил): | | | | | | | | |
| Хамрах хугацаа (өдөр/сар/жил-өдөр/сар/жил): | | | | | | | | |
| № | Тайлбар, лавлах | Байршил | Чөлөөлөгдөх үндэслэл (INFCIRC/188-н заалт) | Материал | Элементийн тоо хэмжээ | Төлөвлөсөн хэрэглээ | | Тайлбар |
| | | | | | | Код | Хэрэглээ | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |



Маягт 7

Баталгаанд хамрагдах хугацаа нь дуусгавар болсон плутони, өндөр баяжуулсан уран, эсвэл уран-233 агуулсан дунд, эсвэл өндөр зэрэглэлийн идэвх бүхий хаягдлын байршил болон цаашдын боловсруулалтад хамаарах мэдээлэл

| | | | | | | | |
|---|--|--|--|--|--|--|--|
| Нэмэлт протоколын 2.а (viii) мэдүүлэг | | | | | | | |
| Мэдүүлгийн №: | | | | | | | |
| Мэдүүлгийн огноо (өдөр/сар/жил): | | | | | | | |
| Хамрах хугацаа (өдөр/сар/жил-өдөр/сар/жил): | | | | | | | |
| А хэсэг: Байршил (өөрчлөлт) | | | | | | | |

| № | Тайлбар, лавлах | Хаягдлын төрөл | Боловсруулалт хийхийн өмнөх хаягдлын төрөл | Бараа материалын тоо хэмжээ | Тоо хэмжээ | | | | Байршил | | Тайлбар |
|---|-----------------|----------------|--|-----------------------------|------------|-----------------------|----------|------|---------|------|---------|
| | | | | | Плутони | Өндөр баяжуулсан уран | Уран-233 | №Атп | Өмнөх | Шинэ | |
| | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | |

Б хэсэг: Нэмэлт боловсруулалт

| № | Тайлбар, лавлах | Хаягдлын төрөл | Боловсруулалтын өмнөх хаягдлын төрөл | Бараа материалын тоо хэмжээ | Тоо хэмжээ | | | | Боловсруулалт | | | Тайлбар |
|---|-----------------|----------------|--------------------------------------|-----------------------------|------------|-----------------------|----------|------|---------------|----------------------|--------------------|---------|
| | | | | | Плутони | Өндөр баяжуулсан уран | Уран-233 | №Атп | Байршил | Боловсруулах байршил | Боловсруулах огноо | |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |

Маягт 8

Нэмэлт протоколын 2 дугаар хавсралтад дурдсан цөмийн бус материалд хамаарах мэдээлэл болон багаж төхөөрөмжийн экспорт, эсвэл импорттой холбоотой мэдээлэл

| Нэмэлт протоколын 2.а (ix) мэдүүлэг | | | | | | | |
|---|-----------------|---------------------|----------------------|--------------------------|----------------------------|------------------------------|---------|
| Мэдүүлгийн №: | | | | | | | |
| Мэдүүлгийн огноо (өдөр/сар/жил): | | | | | | | |
| Хамрах хугацаа (өдөр/сар/жил–өдөр/сар/жил): | | | | | | | |
| № | Тайлбар, лавлах | Хавсралт II ангилал | Бараа материалын нэр | Тоо хэмжээ (жингийн тоо) | Эцсийн хэрэглээний байршил | Импорт эсвэл экспортын огноо | Тайлбар |
| | | | | | | | |
| | | | | | | | |
| | | | | | | | |
| | | | | | | | |
| | | | | | | | |



Маягт 9

Цөмийн түлшний циклд хамаарах эрдэм шинжилгээ, судалгаа хийх, зохион бүтээх ажиллагааг хөгжүүлэхтэй холбоотой дараагийн 10 жилийн ерөнхий төлөвлөгөө

| Нэмэлт протоколын 2.а (х) мэдүүлэг | | | | | |
|---|-----------------|-----------------------|--|--|---------|
| Мэдүүлгийн №: | | | | | |
| Мэдүүлгийн огноо (өдөр/сар/жил): | | | | | |
| Хамрах хугацаа (өдөр/сар/жил–өдөр/сар/жил): | | | | | |
| № | Тайлбар, лавлах | Цөмийн түлшний үе шат | Цөмийн түлшний үе шатыг хөгжүүлэх төлөвлөгөө | Цөмийн түлшний үе шатанд эрдэм шинжилгээ болон туршилт-зохион бүтээх ажиллагааг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө | Тайлбар |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |

ҮНДСЭН ЗЭЭЛИЙН ДУГААР 6594-MN
НЭМЭЛТ ЗЭЭЛИЙН ДУГААР 6833-MN

Санхүүжилтийн хэлэлцээр

(Монгол Улсад КОВИД-19-өөс урьдчилан сэргийлэх,
хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төслийн нэмэлт
Санхүүжилтийн хэлэлцээр)

МОНГОЛ УЛС

болон

ОЛОН УЛСЫН ХӨГЖЛИЙН АССОЦИАЦИ

хоорондын хэлэлцээр



ҮНДСЭН ЗЭЭЛИЙН ДУГААР 6594-МН
НЭМЭЛТ ЗЭЭЛИЙН ДУГААР 6833-МН

САНХҮҮЖИЛТИЙН ХЭЛЭЛЦЭЭР

Энэхүү ХЭЛЭЛЦЭЭР нь МОНГОЛ УЛС (“Хүлээн авагч”) болон ОЛОН УЛСЫН ХӨГЖЛИЙН АССОЦИАЦИ (“Ассоциаци”) нар гарын үсэг зурсан өдрөөр баталгаажна.

Үүнд (А) Хүлээн авагч ба Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хооронд 2020 оны 4 дүгээр сарын 9-ний өдөр байгуулсан гэрээний (“Үндсэн зээлийн гэрээ») хүрээнд Ассоциациас Үндсэн зээлийн гэрээний Хуваарь 1-д тодорхойлсон төслийг (“Үндсэн төсөл») санхүүжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор арван гурван сая найман зуун мянган долларын (13,800,000 ам.доллар) зээл олгохыг зөвшөөрсөн;

(Б) Хүлээн авагч ба Ассоциаци хооронд 2020 оны 4 дүгээр сарын 9-ний өдөр байгуулсан хэлэлцээрийн (“Үндсэн санхүүжилтийн хэлэлцээр”) хүрээнд Үндсэн төслийг санхүүжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Ассоциациас Хүлээн авагчид есөн сая зургаан зуун мянган Зээлжих тусгай эрхтэй тэнцэхүйц (ЗТЭ 9,600,000) зээл олгохыг зөвшөөрсөн;

(В) Хүлээн авагчаас Ассоциацид Үндсэн төслийн хүрээнд хийгдэх нэмэлт үйл ажиллагааг санхүүжүүлэхэд нэмэлт санхүүгийн дэмжлэг болгон Хүлээн авагчид гучин таван сая гурван зуун мянган Зээлжих тусгай эрхтэй тэнцэхүйц (ЗТЭ 35,300,000) нэмэлт зээл (“Нэмэлт зээл”) олгох хүсэлтийг гаргасан; ба

Ассоциаци нь дээр дурдсан болон бусад заасныг үндэслэн Хүлээн авагчид дээрх нэмэлт санхүүгийн дэмжлэгийг энэхүү Хэлэлцээрт заасан нөхцөл, болзлын дагуу олгохоор зөвшөөрсөн;

ИЙМД, Хүлээн авагч ба Ассоциаци Үндсэн санхүүжилтийн хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулж, дахин шинэчлэхийг зөвшөөрсөн ба нэмэлт, өөрчлөлт нь энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн үйлчилнэ.

I БҮЛЭГ - ЕРӨНХИЙ НӨХЦӨЛҮҮД; НЭР ТОМЬЁОНУУД

1.01. Ерөнхий нөхцөлүүд нь (энэхүү Хэлэлцээрийн хавсралтад тусгасан) энэхүү Хэлэлцээрт хүчин төгөлдөр үйлчлэх төдийгүй энэхүү Хэлэлцээрийн салшгүй нэг хэсэг мөн болно.

- 1.02. Хэлэлцээрийн агуулгад өөрөөр заагаагүй бол энэхүү Хэлэлцээрт том үсгээр тэмдэглэсэн нэр томъёонууд нь Ерөнхий нөхцөлүүд, Үндсэн зээлийн гэрээ, эсхүл энэхүү Хэлэлцээрт (Оршил ба хавсралт хэсгийг оролцуулаад) тайлбарласан утгыг илэрхийлнэ.

II БҮЛЭГ - САНХҮҮЖИЛТ

- 2.01. Ассоциаци нь Хүлээн авагчид энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 1-т заасан төслийг (“Төсөл”) санхүүжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Ерөнхий нөхцөлүүдийн хувьд хөнгөлөлттэй санхүүжилт хэмээн тооцогдох дараах үнийн дүн бүхий зээлийг олгохыг зөвшөөрсөн.
- (а) есөн сая зургаан зуун мянган Зээлжих тусгай эрхтэй тэнцэхүйц (ЗТЭ 9,600,000) үнийн дүн бүхий Үндсэн зээл; ба
 - (б) Гучин таван сая гурван зуун мянган Зээлжих тусгай эрхтэй тэнцэхүйц (ЗТЭ 35,300,000) үнийн дүн бүхий Нэмэлт зээл (Үндсэн зээл болон Нэмэлт зээлийг хамтад нь “Санхүүжилт” гэх).
- 2.02. Хүлээн авагч нь энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 2-ын III дахь хэсэгт заасны дагуу санхүүжилтийн хөрөнгийг зарцуулж болно.
- 2.03. Санхүүжилтийн хөрөнгийн ашиглагдаагүй үлдэгдэлд төлөх Хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны жилийн хураамжийн дээд хэмжээ жилд нэг хувийн хагас (1%-ийн 1/2) байна.
- 2.04. Хүлээн авагчийн татаж авсан Зээлийн хөрөнгийн үлдэгдэлд төлөх Үйлчилгээний хураамж нь жилд нэг хувийн дөрөвний гурав (1%-ийн 3/4) байна.
- 2.05. Хүлээн авагчийн татаж авсан Зээлийн хөрөнгийн үлдэгдэлд төлөх Хүүгийн хураамж нь жилд нэг зууны хорин таван хувь (1.25%) байна.
- 2.06. Төлбөр хийх өдөр нь жил бүрийн 4 дүгээр сарын 15 болон 10 дугаар сарын 15-ны өдөр байна.
- 2.07. Үндсэн зээл болон Нэмэлт зээлийн үндсэн төлбөрийг энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 3-т заасан эргэн төлөгдөх хуваарийн дагуу төлж барагдуулна.
- 2.08. Төлбөр гүйцэтгэх мөнгөн тэмдэгт америк доллар байна.

III БҮЛЭГ - ТӨСӨЛ

- 3.01. Хүлээн авагч нь Төслийн болоод олон шатлалт хөтөлбөрийн зорилго, зорилтуудыг хангах үүргийг хүлээнэ. Үүнтэй холбогдуулан Хүлээн авагч нь Ерөнхий нөхцөлүүдийн V Бүлэг болон энэхүү



Хэлэлцээрийн Хуваарь 2-т тусгасан заалтуудын дагуу төслийг хэрэгжүүлнэ.

IV БҮЛЭГ - ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ; ЦУЦЛАХ

- 4.01. Хүчин төгөлдөр болоход тавигдах нэмэлт нөхцөл нь Хүлээн авагч нь Ассоциацийн шаардлагад нийцсэн хэлбэр, агуулга бүхий (а) Төсөл хэрэгжүүлэх гарын авлагыг шинэчилсэн байх; ба (б) Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн удирдлагын болон Оролцогч талуудын оролцооны төлөвлөгөөг шинэчилж, олон нийтэд ил тод болгосон байх.
- 4.02. Хүчин төгөлдөр болох эцсийн хугацаа нь Гарын үсэг зурсан өдрөөс нэг зуун наяд (180) хоног байна.
- 4.03. Ерөнхий нөхцөлүүдийн 10.05 (б) Хэсэгт тусгасны дагуу Хүлээн авагчийн Хэлэлцээрийн хүрээнд хүлээх үүрэг хариуцлага (төлбөрийн үүрэг, хариуцлагаас бусад) гарын үсэг зурсан өдрөөс хорин (20) жилийн дараа дуусгавар болно.

V БҮЛЭГ - ТӨЛӨӨЛӨГЧИД; ХОЛБОГДОХ ХАЯГУУД

- 5.01. Хүлээн авагчийг төлөөлөх этгээд нь түүний тухайн үеийн Сангийн сайд байна.
- 5.02. Ерөнхий нөхцөлүүдийн 11.01-р Хэсэгт заасны дагуу: (а) Хүлээн авагчийн хаяг нь:

Сангийн яам
Засгийн газрын II байр
С.Данзангийн гудамж 5/1 Д
Улаанбаатар 15160
Монгол Улс

мөн

(б) Хүлээн авагчийн цахим хаяг нь:
Факс:
976-11-320247 тус тус болно.

- 5.03. Ерөнхий нөхцөлүүдийн 11.01-р Хэсэгт заасны дагуу: (а) Ассоциацийн хаяг нь:
Олон улсын хөгжлийн ассоциац
1818 Н гудамж, N.W.
Вашингтон хот. 20433
АНУ; мөн



(б) Ассоциацийн цахим хаяг нь:

Телекс:
248423 (МСИ)

Факс:
1-202-477-6391

Хэлэлцээрт гарын үсэг зурсан өдөр ХАРИЛЦАН ТОХИРОЛЦОВ.
Монгол Улсыг төлөөлж
Гарын үсэг зурсан

_____ Эрх бүхий төлөөлөгч

Нэр: _____
Албан тушаал: _____
Огноо: _____

ОЛОН УЛСЫН ХӨГЖЛИЙН АССОЦИАЦИ-ийг төлөөлж

Гарын үсэг зурсан

_____ Эрх бүхий төлөөлөгч

Нэр: _____
Албан тушаал: _____
Огноо: _____

ХУВААРЬ 1

Төслийн тодорхойлолт

Энэхүү төсөл нь КОВИД-19 халдварын тархалтаас сэргийлж, хариу арга хэмжээ авах Монгол Улсын чадавхийг бэхжүүлэх, нийгмийн эрүүл мэндийн бэлэн байдлыг хангах үндэсний тогтолцоог сайжруулах зорилготой юм.

Төсөл нь Олон шатлалт хөтөлбөрийн нэг үе шат байх ба дараах бүрэлдэхүүн хэсгүүдээс бүрдэнэ.

1-р хэсэг: КОВИД-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах

1.1. Эрсдэлийн үеийн харилцаа холбоо, олон нийтийн оролцоо

Дараах арга замуудаар дамжуулан харилцаа холбоо, зан төлөвийн өөрчлөлтийн цогц арга хэмжээг хэрэгжүүлэх: (а) КОВИД-19 халдварын эсрэг арга хэмжээний талаарх түгээх мэдээлэл, материалуудыг боловсруулж, турших; (б) үндэсний түвшнээс аймаг, сумдын түвшинд, төр ба хувийн хэвшил хооронд мэдээллийг түгээх дэд бүтцийг сайжруулах; (в) нийт хүн ам, эмзэг бүлгийн иргэдийн вакцины талаарх мэдлэгийг дээшлүүлэх.

1.2. Хариу арга хэмжээнд үзүүлэх дэмжлэг

1.2.1. Үүнд дараах дэмжлэгийг үзүүлнэ: (а) нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээ, онцгой байдлын удирдлага; (б) тохиолдлын удирдлагын тогтолцоог үндэсний болон орон нутгийн түвшинд ашиглах; (в) эрүүл мэндийн аюулгүй байдлын тогтолцооны гүйцэтгэлийг хянах хяналт-шинжилгээ, үнэлгээний системийг боловсруулах; (г) нийгмийн эрүүл мэндийн онцгой байдал, гамшгийн эрсдэлийн удирдлага тал дээр байгууллага хоорондын уялдаа холбоо, зохицуулалтыг сайжруулах; (д) онцгой байдлын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд тогтолцооны бэлэн байдлыг сайжруулах; мөн (е) эрсдэлийн стратегийн үнэлгээ хийх, эрүүл мэндийн эрсдэл ба нөөцийн зураглал гаргах.

1.2.2. Вакциныг аюулгүй, үр дүнтэй түгээх институцийн тогтолцоог Монгол Улсад бэхжүүлэх, үүнд: (а) вакцин хуваарилалтыг эрэмблэх, дараалал тогтоох үндэсний бодлого боловсруулах; (б) вакцин түгээх, байршуулалтын хяналт-шинжилгээ, үнэлгээний системийг бий болгох; (в) олон нийтийн оролцооны механизмыг бүрдүүлэх.

1.3. Хүний нөөцийн хөгжил

Дараах дэмжлэгийг үзүүлнэ, үүнд: (а) яаралтай тусламжийн эмч, сувилагч, эрчимт эмчилгээний ажилтнуудад сургалт явуулах; (б) КОВИД-19 халдварыг оношлох чадавхыг үндэсний болон орон

нутгийн түвшинд бэхжүүлэх; (в) гамшгийн голомтод ажиллаж байгаа хүмүүст сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх; (г) КОВИД-19 сэжигтэй тохиолдлуудын ангилал, эмчилгээ, удирдлага болон мөшгөлтийн талаар удирдамж боловсруулж, түгээх; (д) КОВИД-19 халдварыг илрүүлсэн, эмчилсэн тухай халдвар судлал ба клиникийн судалгаа хийх, мөн (е) вакцины хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийг бэлтгэх, сургалтын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх.

1.4. “Нэг эрүүл мэнд” үзэл санааг хэрэгжүүлэх таатай орчныг бүрдүүлэх

Дараах дэмжлэгийг үзүүлнэ, үүнд: (а) салбар хоорондын харилцаа холбоо, зохицуулалт, хамтын ажиллагааны хэрэгслүүдийг сайжруулах; (б) нийгмийн эрүүл мэндийн хуулийн хэрэгжилтийг сайжруулах; (в) байгууллага хоорондын хяналт ажиглалтын, эрсдэлийн үнэлгээ хийх; (г) нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үеийн бэлэн байдлыг сайжруулах, үүнд эрүүл мэндийн байгууллагуудын бэлэн байдлыг нэмэгдүүлэх; мөн (д) эрт сэрэмжлүүлэх системийг ажиллуулж, өвчний дэгдэлтийг хянахын тулд өгөгдөл хуваалцах нэгдсэн платформыг боловсруулах.

2-р хэсэг: Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чадавхыг нэмэгдүүлэх

2.1. Эмнэлгийн лабораторийн багаж тоног төхөөрөмж, урвалж бодисоор хангах

Үүнд дараах дэмжлэгийг үзүүлнэ: (а) эрүүл мэндийн байгууллагуудын КОВИД-19 халдварыг оношлох, эмчлэх чадавхыг сайжруулах; мөн (б) эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэг байгууллага, техникийн ажилтнуудад сургалт явуулах.

2.2. Вакцин, хүйтэн хэлхээ, эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгсэл, эмээр хангах

Халдварын тохиолдлын менежмент, халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, эм хэрэгслээр хангах; (б) хавсарсан өвчин, хүндрэлтэй өвчтөнүүдэд зориулсан эмээр хангах; (в) хүн амын сонгосон хэсэгт КОВИД-19 халдварын вакцин худалдан авахад нь Монгол Улсын эрүүл мэндийн салбарт дэмжлэг үзүүлэх, ингэхдээ (i) Ковид-19 вакцины урьдчилсан

худалдан авалтын механизмыг ашиглахад Монгол Улсад дэмжлэг үзүүлэх; ба (ii) Монгол Улсын вакцинтай холбоотой дэд бүтэц, дархлаажуулалтын систем, үйлчилгээ үзүүлэх чадавхыг хөгжүүлэх, түүний дотор хүйтэн хэлхээ, логистикийн дэд бүтцийг өргөтгөх, шинэчлэх барилгын ажлыг гүйцэтгэх, вакцины агуулах, хүйтэн хэлхээний тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслээр хангах, вакцины менежментийн чадавхад үнэлгээ хийх, хүргэлтийн ажилтнуудыг сургаж бэлтгэх; ба (г) хог хаягдал, ариун цэвэр, эрүүл ахуй, хүрээлэн буй орчны эрүүл мэндийн дэд бүтцийг шинэчлэх барилгын ажлыг гүйцэтгэх, хог хаягдлын менежментийн тоног төхөөрөмж, хангамжийн материал худалдан авах.

3-р хэсэг: Төслийн удирдлага, хяналт-шинжилгээ үнэлгээ

Үүнд: (а) клиникийн болон нийгмийн эрүүл мэндийн судалгааны чадавхыг бэхжүүлэх, суралцах боломжийг бүрдүүлэх; (б) төслийн хэрэгжилтэд техникийн болон үйл ажиллагааны дэмжлэг үзүүлэх, зааварчилгаа, зохицуулалтаар хангахын зэрэгцээ: төлөвлөлт ба хэрэгжилт, худалдан авалт, санхүүгийн удирдлага, байгаль орчин ба нийгмийн удирдлага, хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг хариуцах; ба (в) вакцинжуулалт болон эрүүл мэндийн бусад тэргүүлэх хөтөлбөрүүдийн үр дүнг үнэлэх техник туслалцаа.

4-р хэсэг: Онцгой байдлын үед авах хариу арга хэмжээ

Онцгой байдал, гамшгийн үед нэн даруй хариу арга хэмжээ авах.

ХУВААРЬ 2

Төслийн гүйцэтгэл

I-р Хэсэг. Хэрэгжилтийн зохицуулалтууд

A. Институцийн зохицуулалт.

1. Хүлээн авагч нь үндэсний болон орон нутгийн хэмжээнд Ассоциацийн шаардлагад нийцсэн бүрэлдэхүүн, чиг үүрэг, орон тоо, нөөц бололцоо бүхий Төсөл хэрэгжүүлэх бүтцийг төсөл хэрэгжих хугацаанд бүрдүүлж ажиллуулах ба энэ талаар Төсөл хэрэгжүүлэх гарын авлагад заасан байна.
2. Үүгээр хязгаарлагдахгүйгээр Хүлээн авагч нь:

- (а) Эрүүл мэндийн сайдаар ахлуулсан, ЭМЯ, СЯ, болон ХХААХҮЯ-ны төлөөллөөс бүрдсэн, Төслийн хэрэгжилтийг чиглэл, удирдамжаар хангах чиг үүрэг бүхий нэгдсэн Төслийн удирдах хороог ажиллуулна;
- (б) ЭМЯ-ны сайдаар ахлуулсан ЭМЯ, ОБЕГ, МХЕГ болон бусад холбогдох төрийн байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн Төслийн 1.2, 1.3 болон 2.2. хэсэг дэх вакцины түгээлтийг ерөнхий удирдлагаар хангах чиг үүрэг бүхий Зохицуулах хороог байгуулж, ажиллуулна;
- (в) ЭМЯ нь дараах зохион байгуулалтыг хийнэ:
 - (i) КОВИД-19 вакциныг түгээх төлөвлөгөөг хэрэгжүүлэх, зохицуулалт хийж, удирдлагаар хангах үүрэгтэй Төлөвлөлт, менежментийн техникийн ажлын хэсэгтэй байна;
 - (ii) Хүйтэн хэлхээний тоног төхөөрөмж, байгууламжийн бэлэн байдлыг хангах, вакцины орон нутгийн эрэлт, нийлүүлэлтийг тодорхойлох, вакцины захиалга, хүргэлт, хүлээн авах ажлыг хариуцах Вакцины нийлүүлэлт, нийлүүлэлтийн техникийн ажлын хэсэгтэй байна;
 - (iii) эрсдэлийн харилцаа холбоо, олон нийтийн оролцоо, вакцины эргэлзээнд хариу арга хэмжээ авах, эрүүл мэндийн ажилтнууд болон холбогдох оролцогч талуудын чадавхыг бэхжүүлэх, сургах, КОВИД-ын талаар мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, вакцинжуулалт, хүндрэлийн бүртгэл, эрүүл мэндийн хог хаягдлын менежментийг хариуцах Вакцины хөтөлбөрийг дэмжих техникийн ажлын хэсэгтэй байна;
 - (iv) Вакцины аюулгүй байдал, ложистик, тээврийн аюулгүй байдлыг хянах, үнэлэх ажлыг хариуцах Дэмжлэг үзүүлэх тогтолцоо, дэд бүтцийн техникийн ажлын хэсэгтэй байна.
- (г) ЭМЯ-ны харьяа Төсөл хэрэгжүүлэх нэгж байх ба тус нэгж нь төслийн өдөр тутмын хэрэгжилтийг хариуцах буюу (i) жилийн төлөвлөгөө, төсөв боловсруулах, бэлтгэх, (ii) худалдан авалт, санхүүгийн удирдлага, байгаль орчин, нийгмийн нөлөөллийн удирдлага, мөн (iii) төслийн хяналт-шинжилгээ үнэлгээг хийх чиг үүрэгтэй.

Б. Төслийн гарын авлагууд

1. Төсөл хэрэгжүүлэх гарын авлага

Төсөл хэрэгжүүлэх гарын авлагад заасан зохицуулалт, дүрэм журмын дагуу төслийг хэрэгжүүлэхийг Хүлээн авагч баталгаажуулна (Төсөл хэрэгжүүлэх гарын авлага болон энэхүү Хэлэлцээрийн зохицуулалт хооронд аливаа зөрчил гарах тохиолдолд Хэлэлцээрийн заалтууд давуу үйлчилнэ). Ассоциациас урьдчилан бичгээр зөвшөөрөл аваагүй бол Төсөл хэрэгжүүлэх гарын авлагын аль нэг заалтыг өөрчлөх, хүчингүй болгох боломжгүй.

2. Вакцин хүргэх, түгээх гарын авлага

Энэ хэсгийн 1 дэх заалтаар хязгаарлагдахгүйгээр Төслийн 1.2, 1.3, 2.2 хэсгүүдийн зохистой хэрэгжилтийг хангах үүднээс Хүлээн авагч нь Төсөл хэрэгжүүлэх гарын авлагын нэг хэсэг болгон батласан Ассоциацийн шаардлагад нийцсэн хэлбэр, агуулга бүхий КОВИД-19 вакцин хүргэх, түгээх гарын авлагыг (“Вакцин хүргэх, түгээх гарын авлага”) хэрэгжүүлнэ. Үүнд:

- (а) ДЭМБ-ын Шударга хуваарилалтын тогтоосон зарчмуудын дагуу улс дотроо вакциныг хуваарилах, эрэмбэлэх дүрэм, журам, уг журмыг хэрэгжүүлэх хугацаа, үе шатуудыг тусгасан үйл ажиллагааны төлөвлөгөө;
- (б) вакцины удирдлага, хяналт шинжилгээний хамгийн минимум стандартыг тогтоосон дүрэм, журам, үүнд эмнэлгийн болон техникийн шалгуур, харилцаа холбоо, хүрч үйлчлэх төлөвлөгөө, хүйтэн хэлхээний дэд бүтэц, бусад холбогдох ложистикийн дэд бүтэц;
- (в) олон улсын сайн туршлагын дагуу Хувийн нууцлалтай мэдээлэл цуглуулах дүрэм, журам; болон
- (г) вакцин тараах төлөвлөгөө, үүнд дархлаажуулалтын хугацаа, үе шатыг тодорхойлсон үйл ажиллагааны төлөвлөгөө багтана.

В. Жилийн ажлын төлөвлөгөө, төсөв

1. Хүлээн авагч нь төсөл хэрэгжих хугацаанд энэхүү хуваарийн Г Хэсэгт заасан байгаль орчин, нийгмийн хамгааллын талаар

авч хэрэгжүүлсэн болон авч хэрэгжүүлэх бүхий л арга хэмжээг багтаасан, ирэх санхүүгийн жилд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй бүхий л үйл ажиллагаа, зардлыг багтаасан Жилийн ажлын нэгдсэн төлөвлөгөө, төсвийг (ЖАНТТ) санхүүгийн жил тус бүрийн 12 дугаар сарын 1-ний дотор (эсхүл Ассоциациас тогтоосон хожуу хугацаанд) боловсруулан бэлтгэж, ЭМЯ-аар дамжуулан Ассоциацид зөвшөөрөл авахаар хүргүүлнэ.

2. Хүлээн авагч нь төслийг Ассоциациас баталсан тухайн санхүүгийн жилийн ЖАНТТ-ийн дагуу хэрэгжүүлж байгаа эсэхэд хяналт тавина. ЖАНТТ болон энэхүү Хэлэлцээрийн зохицуулалт хооронд аливаа зөрчил гарах тохиолдолд Хэлэлцээрийн заалтууд давуу үйлчилнэ.
3. Хүлээн авагч нь Ассоциациас урьдчилан бичгээр зөвшөөрөл авалгүйгээр ЖАНТТ-ийн аль нэг заалтыг өөрчлөх, хүчингүй болгох боломжгүй.

Г. Цэрэг, цагдаагийн байгууллагуудын оролцоо

1. ЦЕГ-ын эсхүл цэрэг, цагдаагийн байгууллагын зүгээс төслийн хүрээнд авч хэрэгжүүлэх бүх үйл ажиллагаа ЭМЯ-ны хяналтан доор явагдах ба зөвхөн төсөлд хамааралтай үйл ажиллагаанд хамаарах ёстой. ЦЕГ эсхүл цэрэг, цагдаагийн байгууллагад хамаарах бараа, ажил, үйлчилгээ, үйл ажиллагааны зардал, вакцин түгээхтэй холбоотой нэмэлт зардал болон сургалтын зардлыг ЭМЯ-ны заавар, хяналтан дор Зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэх ба ингэхдээ Төсөл хэрэгжүүлэх гарын авлага болон холбогдох үйл ажиллагааг явуулахад Ассоциациас шаардах бусад зохицуулалт, протоколыг хатуу баримтална.
2. Ассоциаци өөрөөр зөвшөөрөхөөс бусад тохиолдолд Хүлээн авагч нь Зээлийн хөрөнгөөр санхүүжүүлсэн ЦЕГ эсхүл аливаа цэрэг, цагдаагийн байгууллагад хамаарах аливаа эд хогшил, худалдан авсан бараа, гүйцэтгэсэн ажлыг ЭМЯ эсхүл Ассоциацийн зөвшөөрсөн түүнтэй адилтгах байгууллага эсхүл зохих яам, агентлагийг өмчлөлд шилжүүлнэ.

Д. Байгаль орчин, нийгмийн хамгааллын стандартууд.

1. Хүлээн авагч нь төслийг Байгаль орчин, нийгмийн хамгааллын стандартуудад нийцүүлэн, Ассоциацийн хүлээн зөвшөөрөгдөхүйц байдлаар хэрэгжүүлнэ.

2. Дээрх 1-р хэсэгт зааснаас гадна, Хүлээн авагч нь төслийг Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөөний (“БОНУАТ”) дагуу, Ассоциацийн хүлээн зөвшөөрөгдөхүйц байдлаар хэрэгжүүлнэ. Энэ үүднээс Хүлээн авагч нь:
 - (a) БОНУАТ-д заасан арга хэмжээ, үйл ажиллагааг зүй ёсоор, үр ашигтай байдлаар, мөн БОНУАТ-д тусгагдсаны дагуу хэрэгжүүлсэн байх;
 - (б) БОНУАТ-г хэрэгжүүлэхэд хангалттай хэмжээний хөрөнгийг байлгах;
 - (в) БОНУАТ-нд заасан журам, дүрмийг мөрдөж, тус БОНУАТ-г хэрэгжүүлэхэд шаардлагатай ур чадвар бүхий, хангалттай тооны ажилтнуудтай байх; мөн
 - (г) БОНУАТ-нд заасны дагуу тус төлөвлөгөөний аль нэг заалтад Ассоциацитай бичгээр зөвшилцөлгүйгээр нэмэлт, өөрчлөлт оруулахгүй, хүчингүй болгохгүй, түдгэлзүүлэхгүй байх, мөн нэмэлт засвар оруулсан бол тус өөрчлөлтийг нэн даруй танилцуулах.
3. БОНУАТ болон энэхүү Хэлэлцээрийн зохицуулалт хооронд аливаа зөрчил гарах тохиолдолд Хэлэлцээрийн заалтууд давуу үйлчилнэ.
4. Хүлээн авагч нь ЭМЯ-аар дамжуулан Төслийн үйл ажиллагаанд цэрэг, цагдаагийн албан хаагчдыг оролцуулах тохиолдолд Ассоциацийн хүлээн зөвшөөрөгдөхүйц дараах байдлаар авч хэрэгжүүлнэ:
 - (a) Цэрэг, цагдаагийн албан хаагчдыг сонгох, тэдгээрийг оролцуулах стандарт, протокол, ёс зүйн дүрмийг баталж мөрдүүлэх, эдгээр албан хаагчид өмнө нь хууль бус үйл ажиллагаа, хүчирхийлэл, тэр дундаа бэлгийн мөлжлөг, бэлгийн дарамт эсхүл хэт хүч хэрэглэж байгаагүй болохыг шалгах;
 - (б) ЭМЯ нь ЦЕГ-тай Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулж, цэрэг, цагдаагийн албан хаагчдыг Төслийн үйл ажиллагаанд оролцуулах зохицуулалтыг тусгаж өгөх ба БОНУАТ-ний холбогдох заалтуудыг мөрдлөг болгож ажиллахыг мөн тусгасан байх.
 - (в) Эдгээр албан хаагчдыг Байгаль орчин, нийгмийн хамгааллын стандарт болон БОНУАТ-ний холбогдох шаардлагуудын дагуу оролцуулах явдлыг баталгаажуулах;
 - (г) Төсөл хэрэгжүүлэх гарын авлага болон БОНУАТ-нд заасны дагуу эдгээр албан хаагчдыг төслийн үйл ажиллагаанд тогтмол оролцуулахаас өмнө хүч хэрэглэх,

- зохистой харьцааны талаар (энгийн иргэд-хүчний байгууллага хоорондын харилцаа болон бусад чиглэлээр) зохих зааварчилгаагаар хангаж, бэлтгэсэн байх;
- (д) Оролцогч талуудын оролцооны үйл ажиллагааг тусгасан Оролцогч талуудын оролцооны төлөвлөгөөнд Төслийн үйл ажиллагаанд цэрэг, цагдаагийн албан хаагчдыг хамруулах харилцааны стратегийг багтаасан байх; мөн
- (е) Эдгээр албан хаагчдын үйл ажиллагаатай холбоотой санал, гомдлын хүлээн авч, хянах, баримтжуулах, шийдвэрлэхдээ Төслийн санал, гомдол барагдуулах механизмыг ашиглах (нууцлалыг хамгаалах хэрэгцээг харгалзан) ба энэ тухай Ассоциацид тухайн санал, гомдол хүлээн авснаас арван дөрөв (14) хоногийн дотор мэдэгдэх.
5. Хүлээн авагч дараах зүйлсэд анхаарна:
- (а) БОНУАТ болон түүнд багтсан байгаль орчин, нийгмийн хамгааллын хэрэгслүүдийг хэрхэн мөрдөж байгаа талаарх мэдээллийг БОНУАТ-нд заасан давтамжийн дагуу цаг тухайд нь Ассоциацид хүргүүлж, Ассоциациас шаардсан бол тус мэдээллийг тусдаа тайлан эсхүл хэд хэдэн тайлан хэлбэрээр хүргүүлэх бөгөөд Ассоциацийн шаардлагад нийцүүлэн тус тайлангуудад дараах мэдээллийг багтаасан байна: (i) БОНУАТ-ний хэрэгжилтийн байдал; (ii) БОНУАТ-ний хэрэгжилтэд тулгамдаж байгаа эсхүл саад болж болзошгүй аливаа нөхцөл үүссэн бол тэдгээрийг дурдах; мөн (iii) тэдгээр нөхцөл байдлыг арилгахын тулд авч хэрэгжүүлсэн эсхүл хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг тусгах; мөн
- (б) Төсөлтэй холбоотой эсхүл төслийн хэрэгжилтэд нөлөөлөхүйц үйл явдал тохиолдсон, осол гарсан эсхүл гарч болзошгүй бол, мөн уг нөхцөл байдлын улмаас БОНУАТ болон түүнд заасан байгаль орчин, нийгмийн хамгааллын хэрэгсэл, Байгаль орчин нийгмийн хамгааллын стандартад заасны дагуу байгаль орчин, төсөл хэрэгжиж байгаа газрын иргэд, олон нийт, ажилтнуудад ноцтой сөрөг нөлөө үзүүлэхээр байгаа бол энэ тухай Ассоциацид шуурхай мэдээлэх.
6. Хүлээн авагч нь ашиглахад хялбар гомдол барагдуулах механизмыг байгуулж, энэ тухайгаа мэдээлэх ба, тус механизмыг ажиллуулах ба Төслийн үйл ажиллагаа нөлөөлж буй хүмүүсийн

гомдлыг хүлээж авч шийдвэрлэхдээ Ассоциацийн шаардлагад нийцүүлэн, бүх шаардлагатай арга хэмжээг авна.

7. Хүлээн авагч нь Төслийн хүрээнд хийгдэж байгаа бүх барилгын ажлын тендерийн бичиг баримт, гэрээнүүд нь гэрээлэгч, дэд гэрээлэгч ба удирдан чиглүүлж байгаа байгууллагын үүрэг хариуцлагыг багтаасан байна. Үүнд:

(а) БОНУАТ ба түүнд заасан байгаль орчин, нийгмийн хамгааллын хэрэгслүүдийн холбогдох хэсгүүдийг дагаж мөрдөх; ба (б) байгаль орчин, нийгэм, эрүүл мэнд ба аюулгүй байдлын эрсдэлүүд, бэлгийн дарамт ба хүчирхийлэл, хүүхдийн эсрэг бэлгийн дарамт хүчирхийллийн эрсдэлийг шийдвэрлэх арга хэмжээнүүдийг нарийвчлан заасан ёс зүйн журмыг боловсруулан, бүх ажилчдаар гарын үсэг зуруулан, мөрдүүлэх бөгөөд дээр дурдсан гэрээний дагуу хийгдэх барилгын ажлуудад ашиглана.

Е. Онцгой байдлын үед авах хариу арга хэмжээ

1. Төслийн 4 дүгээр хэсэгт (Онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний тухай хэсэг) заасан ноцтой байдлын эсрэг авах арга хэмжээнүүдийн зохистой хэрэгжилтийг хангахын тулд, Хүлээн авагч нь дараах үүргийг хүлээнэ:

(а) Онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний хэсгийн хэрэгжилтийн нарийвчилсан зохицуулалтыг тусгасан Онцгой байдлын гарын авлагыг (“ОБГА”) боловсруулан, Ассоциациар батлуулах бөгөөд үүнд: (i) Онцгой байдлын үед авах арга хэмжээг зохицуулж, хэрэгжүүлэх байгууллагын тусгай зохицуулалтууд; (ii) Онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний хэсэгт оруулж болох тусгай үйл ажиллагаанууд, үүнийг хэрэгжүүлэхэд шаардлагатай Зөвшөөрөгдөх зардлууд (“Онцгой байдлын зардлууд”), ба үүнтэй холбоотой ажиллагааны үе шат; (iii) Онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний санхүүгийн удирдлагын зохицуулалтууд; (iv) Онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний хэсгийн худалдан авах аргачлал, ажиллагааны үе шат; (v) Онцгой байдлын зардлуудыг санхүүжүүлэхэд шаардагдах бичиг баримт; (vi) Онцгой байдлын үед авах арга хэмжээнд Хамгааллын хэрэгслүүд болон бусад холбогдох хамгааллын хэрэгслүүдийг ашиглах; мөн (vii) Онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний тухай хэсгийн зохицуулалт, хэрэгжилтийг хангахад шаардлагатай бусад зохицуулалтууд;

- (б) Ассоциацид ОБГА-ыг үзэж танилцахад хангалттай хугацаа олгох;
- (в) Ассоциациас зөвшөөрөл олгосон тохиолдолд ОБГА-ыг Онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний тухай хэсгийн нэг хэсэг болгон нэн даруй батлах;
- (г) Онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний тухай хэсэг нь ОБГА-ын дагуу хэрэгжиж байгаад анхаарах; ОБГА болон энэхүү Хэлэлцээрийн зохицуулалт хооронд аливаа зөрчил гарах тохиолдолд Хэлэлцээрийн заалтууд давуу үйлчилнэ; ба
- (д) Ассоциациас урьдчилан бичгээр зөвшөөрөл аваагүй бол ОБГА-ын аливаа заалтад өөрчлөлт оруулахгүй, хүчингүй болгохгүй байх.

2. Хүлээн авагч нь дараах нөхцөл байдал үүсэхээс нааш Онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний тухай хэсгийн дагуу ямар нэг арга хэмжээ авахгүй:

- (а) Хүлээн авагч нь Хүлээн зөвшөөрөхүйц хямрал, онцгой тохиолдол болсныг тогтоож, тус хямрал, онцгой тохиолдлын эсрэг авах арга хэмжээнүүдийг Онцгой байдлын үед авах арга хэмжээний тухай хэсэгт багтаах хүсэлтийг Ассоциацид гаргаж, Ассоциаци тус тодорхойлолтыг хүлээн зөвшөөрөн, хүсэлтийг хүлээн авч Хүлээн авагчид мэдэгдсэн; мөн
- (б) Хүлээн авагч нь ОБГА-ын дагуу тус арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах бүх хамгааллын хэрэгслүүдийг бэлтгэж, мэдээлсэн байх, Ассоциаци тус хэрэгслүүдийг зөвшөөрч, Хүлээн авагч нь тус хэрэгслүүдэд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байх.

Ё. КОВИД-19 Төслийн Вакцин батлах стандарт.

Бүх КОВИД-19 Төслийн вакцин нь Вакцин батлах шалгуурыг хангасан байх ёстой.

II-р хэсэг. Төслийн хяналт-шинжилгээ, үнэлгээ ба тайлагналт

A. Төслийн тайлангууд

Хүлээн авагч нь Төсөл тус бүрийн тайланг хуанлийн улирал дуусах бүрд үүнээс нэг (1) сараас хойшгүй хугацаанд багтаан тухайн хуанлийн улирлыг хамаарсан тайланг Ассоциацид өгнө.

Б. Дунд хугацааны үнэлгээ

Хүлээн авагч нь: (а) Хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш арван найман (18) сарын дараа Ассоциацид дунд хугацааны тайланг бэлтгэж хүргүүлнэ. Ингэхдээ Ассоциациас шаардаж болох мэдээллийг оруулан, тус тайланг гаргахаас өмнөх хугацааны туршид Төслийг хэрэгжүүлэхэд гарсан ахиц дэвшлийг баримтжуулж, энэхүү хэсгийн А хэсэгт заасны дагуу хэрэгжүүлэх хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагааг бодолцон үзэж, тус тайланг гаргаснаас хойших хугацаанд Төслийг амжилттай хэрэгжүүлэх, төслийн зорилтуудад хүрэхэд авч хэрэгжүүлж болох арга хэмжээнүүдийг заана; мөн (б) тайланг хүргүүлснээс хойш дөчин тав (45) хоногийн дараа тус дунд хугацааны тайланг Ассоциацид хамтран хянаж, дунд хугацааны тайлангийн дүгнэлт, зөвлөмж болон тухайн асуудлын талаарх Ассоциацийн үзэл бодолд үндэслэн Төслийг цаашид амжилттай хэрэгжүүлж, зорилгуудыг хангах үүднээс шаардлагатай бүх арга хэмжээг авна.

В. Энэхүү Хэлэлцээрт тусгайлан заасан эсхүл Ассоциациас шаардсанаас бусад тохиолдолд Хүлээн авагч нь энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 1-т заасан үйл ажиллагаануудтай холбоотой аливаа мэдээлэл, тайлан эсхүл бичиг баримтыг хуваалцахдаа тус мэдээлэл, тайлан, бичиг баримтад Хувийн нууцлалтай мэдээлэл байхгүй байх тал дээр анхаарна.

III Хэсэг. Санхүүжилтийн хөрөнгийн зарцуулалт

A. Ерөнхий

Ерөнхий нөхцөлүүдийн II Зүйл болон Ассоциациас Хүлээн авагчид хүргүүлэх Зарцуулалтын болон санхүүгийн мэдээллийн албан захидлын дагуу Хүлээн авагч нь доорх хүснэгт дэх ангилал тус бүрд хуваарилагдсан зээлийн хэмжээ болон хамаарах

санхүүжилтийн хувь хэмжээнд нийцүүлэн санхүүжилтийг татан авч Зөвшөөрөгдсөн зардлыг санхүүжүүлж болно:

| Ангилал | Үндсэн зээлийн хөрөнгийн хуваарилалт (ЗТЭ-ээр) | Нэмэлт зээлийн хөрөнгийн хуваарилалт (ЗТЭ-ээр) | Зардлын санхүүжилтийн хувь хэмжээ (Татвар тооцсон) |
|---|--|--|--|
| (1) Төслийн 1, 2, болон 3 дугаар хэсэгт хамаарах бараа, ажил, зөвлөхийн бус үйлчилгээ, үйл ажиллагааны зардал, сургалт, вакцин түгээх нэмэлт зардал | 9,600,000 | 35,300,000 | 100% |
| (2) Төслийн 4 дүгээр хэсэгт хамаарах онцгой байдлын зардал | 0 | 0 | 100% |
| НИЙТ ДҮН | 9,600,000 | 35,300,000 | |

Б. Хөрөнгө зарцуулах нөхцөлүүд; зарцуулах хугацаа

1. Хэсэг А-д заасан заалтуудаас үл хамаарч дараах төлбөрүүдэд зарцуулалт хийхгүй:
 - (a) (i) Үндсэн Хэлэлцээр байгуулсан өдрөөс өмнө хийсэн төлбөр, үүнд Ангилал (1)-т хамаарах Зөвшөөрөгдсөн зардлуудыг санхүүжүүлэхээр 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр болон түүнээс хойш хийсэн Үндсэн зээлийн төлбөрүүд хамаарахгүй байж болох авч тэдгээрийн нийлбэр дүн нь 1,500,000 ЗТЭ-ээс хэтэрч үл болно; (ii) Нэмэлт зээлийн тухайд Хэлэлцээрт гарын үсэг зурсан өдрөөс өмнө хийсэн бол; эсхүл
 - (б) Ангилал (2)-т хамаарах Онцгой байдлын зардал. Гэвч Хүлээн авагч нь холбогдох зардалтай холбоотой дараах бүхий л нөхцөлүүдийг хангасан болохыг Ассоциаци хүлээн зөвшөөрч, түүнд тийнхүү мэдэгдсэн бол тухайн зардлыг санхүүжүүлж болно. Үүнд:



- (i) Хүлээн авагч нь Зөвшөөрөгдөх хямрал эсхүл онц байдал үүссэн болохыг тогтоож, Ассоциацид тухайн хямрал, онц байдалд хариу ажиллагаа явуулах зорилгоор Онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний хэсэгт санал болгож буй үйл ажиллагааг оруулах хүсэлт ирүүлж, улмаар Ассоциаци тийнхүү дүгнэж, тухайн хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэснээ Хүлээн авагчид мэдэгдсэн;
- (ii) Хүлээн авагч нь тухайн үйл ажиллагаанд шаардлагатай аливаа хамгааллын хөтөлбөр боловсруулж, нийтэд ил болгосон бөгөөд Хуваарь 2-ын Хэсэг I.Д ба I.Е-д тус тус заасан заалтууд (мөн энэхүү Хавсралтын Хэсэг I-т заасан холбогдох заалтуудын хамт)-ын дагуу тухайн хөтөлбөрүүдийн хүрээнд шаардлагатай бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлсэн;
- (iii) Хуваарь 2-ын Хэсэг I.Е-д заасан заалтууд (мөн энэхүү Хавсралтын Хэсэг I-т заасан холбогдох заалтуудын хамт)-ын дагуу Онцгой байдлын үед авах хариу арга хэмжээг уялдуулан зохицуулах болон хэрэгжүүлэх үүрэгтэй байгууллагуудад тухайн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүн хүч болон бусад хүч нөөцөөр хангасан байх; мөн
- (iv) Хүлээн авагч нь Ассоциацийн шаардлагад хэлбэр, агуулгын хувьд бүрэн нийцэх Онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний төлөвлөгөөг нэвтрүүлэх бөгөөд тус төлөвлөгөөний заалтууд эсхүл энэхүү Хуваарь 2-ын Хэсэг I.Е-д заасан заалтуудын дагуу шинэчилсэн заалтууд нь Онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний хэсгийг хамруулан хэрэгжүүлэхэд оновчтой хэвээр байна.

2. Төсөл хаах өдөр нь 2023 оны 3 дугаар сарын 31-ний өдөр байна.



ХУВААРЬ 3

Эргэн төлөлтийн хуваарь

I. ҮНДСЭН ЗЭЭЛИЙН ЭРГЭН ТӨЛӨЛТИЙН ХУВААРЬ

| Төлбөр хийх огноо | Эргэн төлөх зээлийн үндсэн хэмжээ (хувиар илэрхийлэв)* |
|---|--|
| Жил бүрийн 4 дүгээр сарын 15 ба 10 дугаар сарын 15: | |
| 2025 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн 2044 оны 10 дугаар сарын 15-ны өдрийг оролцуулан | 1.65% |
| 2045 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн 2049 оны 10 дугаар сарын 15-ны өдрийг оролцуулан | 3.40% |

II. НЭМЭЛТ ЗЭЭЛИЙН ЭРГЭН ТӨЛӨЛТИЙН ХУВААРЬ

| Төлбөр хийх огноо | Эргэн төлөх зээлийн үндсэн хэмжээ (хувиар илэрхийлэв)* |
|---|--|
| Жил бүрийн 4 дүгээр сарын 15 ба 10 дугаар сарын 15: | |
| 2026 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн 2045 оны 10 дугаар сарын 15-ны өдрийг оролцуулан | 1.65% |
| 2046 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн 2050 оны 10 дугаар сарын 15-ны өдрийг оролцуулан | 3.40% |

* Ерөнхий нөхцөлүүдийн 3.05 (б) хэсэгт заасны дагуу Ассоциациас өөрөөр заагаагүй бол дээрх хувь хэмжээ нь эргэн төлөгдөх үндсэн зээлийн хувь хэмжээг илэрхийлнэ.

ХАВСРАЛТ

1-р Хэсэг. Нэр томьёо

1. “Жилийн үйл ажиллагааны төсөв, төлөвлөгөө” буюу ЖУАТТ гэсэн товчлол нь энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 2-ын В хэсэгт дурдсан



- төлөвлөгөө ба төсвийг хэлнэ, тус төлөвлөгөөг Ассоциациас урьдчилан бичгээр зөвшөөрөл авсны үндсэн дээр тухай бүр шинэчлэх боломжтой.
2. “Авилгын эсрэг журам” гэж Ерөнхий нөхцөлүүдийн Хавсралт дахь 5 дугаар хэсэгт заасан 2006 оны 10 дугаар сарын 15-нд батлагдсан, 2011 оны 01 дүгээр сар болон 2016 оны 7 дугаар сарын 01-нд тус тус шинэчилсэн “Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банкны зээл болон Олон улсын хөгжлийн ассоциацийн зээл, буцалтгүй тусламжийн санхүүжилт бүхий төслүүдэд Луйвар, залилан, авилгаас урьдчилан сэргийлэх, тэмцэх журам”-ыг хэлнэ.
 3. “Ангилал” гэж энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 2-ын III.A хэсэг дэх хүснэгтэд заагдсан ангиллыг хэлнэ.
 4. “Ковид-19” гэж 2019 онд гарсан шинэ төрлийн титэм вирус (SARS-CoV-2)-ээс гаралтай титэм вирусын гаралтай өвчнийг хэлнэ.
 5. “Хамаарах хямрал эсхүл онцгой тохиолдол” гэж Хүлээн авагчид эдийн засгийн ба/эсхүл нийгмийн ихээхэн сөрөг нөлөө үзүүлсэн эсхүл үзүүлэхүйц, байгалийн болоод хүний хүчин зүйлээс хамааралтай хямрал эсхүл гамшгийг хэлнэ.
 6. “Онцгой байдлын зардлууд” гэж энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 2-ийн I.E-ийн дагуу онцгой байдлын үед авах хариу арга хэмжээ бүрэлдэхүүн хэсгийн дагуу онцгой байдлын үед гарах зөвшөөрөгдсөн аливаа зардлыг хэлнэ.
 7. “Онцгой байдлын гарын авлага” буюу “ОБГА” гэж энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 2-ын I.E.1-ийн (а)-д заасан гарын авлагыг хэлэх ба Хүлээн авагч энэхүү хэсэгт дурдсаны дагуу Онцгой байдлын үед авах хариу арга хэмжээний гарын авлагыг батлан мөрдүүлнэ.
 8. “Онцгой байдлын үед авах хариу арга хэмжээ бүрэлдэхүүн хэсэг” гэж төслийн Бүрэлдэхүүн хэсэг 4-ийн хүрээнд хямрал эсхүл гэнэтийн тохиолдолд авч хэрэгжүүлэх тодорхой арга хэмжээ эсхүл үйл ажиллагааг хэлнэ.
 9. “Онцгой байдлын үед ашиглах зөвшөөрөл” гэж нийгмийн эрүүл мэндийн улсын онцгой байдлын зэрэгт шилжсэн хугацаанд эмнэлгийн хариу арга хэмжээ (вакциныг хамрагдана) авах, авах боломжийг бүрдүүлэх зорилгоор Хатуу зохицуулалттай байгууллагаас олгосон зөвшөөрлийг хэлнэ.
 10. “Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө” эсхүл “БОНУАТ” гэж төслийн зориулалтаар 2020 оны 3 дугаар сарын 25-ны өдөр баталсан, 2021 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр шинэчилсэн, холбогдох заалтын дагуу тухай бүр нэмэлт өөрчлөлт оруулах боломжтой байгаль орчны болон нийгмийн хамгааллын

төлөвлөгөөг хэлэх ба үүнд төслийн хэрэгжилтээс үүдэн байгаль орчин, нийгэмд учирч болзошгүй эрсдэл, нөлөөллийг шийдвэрлэх зорилгоор авч хэрэгжүүлэх биет арга хэмжээ, үйл ажиллагаа буюу тэрхүү арга хэмжээг авч хэрэгжүүлэх цаг хугацааны, институцийн, хүн хүчний, хяналт-шинжилгээний, тайлагнах зохицуулалтууд болон байгаль орчин, нийгмийн хамгааллын хувьд бэлтгэх шаардлагатай аливаа арга хэрэгслийг тусгасан байна.

11. “Байгаль орчин, нийгмийн хамгааллын хүрээ” гэж Ассоциацийн шаардлагад нийцүүлэн Хүлээн авагчийн бэлтгэн, 2020 оны 11 дүгээр сард баталсан, төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэмд учирч болзошгүй сөрөг эрсдэл, нөлөөллийг (эрүүл мэнд, аюулгүй байдлын асуудал орж буй), үүнд жендэрт суурилсан хүчирхийлэл, бэлгийн мөлжлөг, хүчирхийллийн эрсдэлийг ялгах, үнэлэх зарчим, дүрэм, удирдамж, журмыг тодорхойлсон; хүрээлэн буй орчин, нийгмийн сөрөг эрсдэл, нөлөөллөөс зайлсхийх, бууруулах, нөхөн сэргээх үүднээс авах арга хэмжээ, үүнд: зарчим, зохион байгуулалтын зохицуулалт (зөвлөлдөх, төсөв, тодруулга орно); жендэрт суурилсан хүчирхийлэл, бэлгийн мөлжлөг, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, эдгээр арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах процедур, төсөв, байгууллагын зохион байгуулалт, арга хэмжээ, төслийн эрсдэл, нөлөөллийг шийдвэрлэх үүрэг бүхий агентлаг, агентлагуудын талаарх мэдээллийг тусгасан; түүнчлэн энд дурдсан байгаль орчны болон нийгмийн аливаа хэрэгслийг бэлтгэх зарчим, дүрэм, удирдамж, журмыг тодорхойлсон, Ассоциациас урьдчилсан бичгээр зөвшөөрөл авсны дагуу Хүлээн авагч тухай бүр нэмэлт, өөрчлөлт оруулж болох байгаль орчин, нийгмийн хамгааллын төлөвлөгөөг хэлнэ.

12. “Байгаль орчин, нийгмийн хамгааллын стандарт” буюу “БОНС” гэж 2018 оны 10 дугаар сарын 1-нээс хүчин төгөлдөр үйлчилж буй Ассоциациас хэвлэн гаргасан дараах стандартуудыг нийтэд нь хэлнэ: Үүнд: (i) “Байгаль орчин, нийгмийн хамгааллын стандарт 1: Байгаль орчны болон нийгмийн хамгааллын эрсдэл, нөлөөллийн үнэлгээ”; (ii) “Байгаль орчин, нийгмийн хамгааллын стандарт 2: Хөдөлмөрийн ба ажиллах нөхцөлүүд”; (iii) “Байгаль орчин, нийгмийн хамгааллын стандарт 3: Нөөцийн зохистой ашиглалт, бохирдлоос сэргийлэх, удирдах”; (iv) “Байгаль орчин, нийгмийн хамгааллын стандарт 4: Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал”; (v) “Байгаль орчин, нийгмийн хамгааллын стандарт 5: Газар эзэмшил, газар ашиглалтын хязгаарлалтууд, албадан нүүлгэх”; (vi) “Байгаль орчин, нийгмийн хамгааллын стандарт 6: Биологийн төрөл зүйлийн хамгаалалт, амьд байгалийн нөөцийн

- тогтвортой удирдлага”; (vii) “Байгаль орчин, нийгмийн хамгааллын стандарт 7: Үндэсний цөөнх/Сахарын цөл орчмын орон нутгийн иргэдийн уламжлалт ялгаварлал”; (viii) “Байгаль орчин, нийгмийн хамгааллын стандарт 8: Соёлын өв”; (ix) “Байгаль орчин, нийгмийн стандарт 9: Санхүүгийн зуучлал”; (x) “Байгаль орчин, нийгмийн хамгааллын стандарт 10: Оролцогч талуудын оролцоо болон мэдээллийг нээлттэй болгох”.
13. “МХЕГ” гэж Хүлээн авагчийн Мэргэжлийн хяналтын ерөнхий газрыг эсхүл түүний чиг үүргийг залгамжлагч байгууллагыг хэлнэ.
 14. “Ерөнхий нөхцөлүүд” гэж ОУХА-ийн Санхүүжилтийн Ерөнхий нөхцөлүүд буюу 2018 оны 12 дугаар сарын 14-нд батлагдсан Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банкны Хөрөнгө оруулалтын төслийн санхүүжилтийн Ерөнхий нөхцөлүүдийг.
 15. “ЦЕГ” гэж Хүлээн авагчийн Цагдаагийн ерөнхий газрыг эсхүл түүний чиг үүргийг залгамжлагч байгууллагыг хэлнэ.
 16. “Вакцин түгээх нэмэлт зардал” гэж Ассоциаттай тохирсны дагуу Төсөл хэрэгжүүлэх гарын авлагад заасан хэмжээ хүртэлх болон Хүлээн авагчийн гаргасан боломжийн зардлыг хэлэх ба үүнд: (а) шалгуур хангаж буй эрүүл мэндийн ажилтнуудад [Ковид-19-өөс урьдчилан сэргийлэх вакцин] [Ковид-19 вакцин] түгээхэд зориулан олгох урамшууллын багц (Хүлээн авагчийн төрийн албан хаагчдын цалин хөлс, шагнал урамшуулал, нэмэгдэл буюу түүнтэй адилтгах төлбөрийг оролцуулахгүй); ба (б) [Ковид-19-өөс урьдчилан сэргийлэх вакцин] [Ковид-19 вакцин]-ыг дотооддоо түгээхэд шаардагдах автомашины түлш (Төслийн бусад өдөр тутмын үйл ажиллагааг удирдах зохицуулах, хянахад шаардагдах түлшийг оруулахгүй).
 17. “Зохицуулах хороо” гэж энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 2-ын I.A.2. (Б) хэсэгт заасны дагуу Хүлээн авагчийн байгуулан ажиллуулах хороог эсхүл түүний чиг үүргийг залгамжлагч байгууллагыг хэлнэ.
 18. “Нэгдсэн Төслийн удирдах хороо” гэж энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 2-р I.A.2. (А) хэсэгт заасны дагуу Хүлээн авагчийн байгуулан ажиллуулах хороо эсхүл түүний чиг үүргийг залгамжлагч байгууллагыг хэлнэ.
 19. “СЯ” гэж Хүлээн авагчийн Сангийн яам эсхүл түүний чиг үүргийг залгамжлагч байгууллагыг хэлнэ.
 20. “ХХААХҮЯ” гэж Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам эсхүл түүний чиг үүргийг залгамжлагч байгууллагыг хэлнэ.
 21. “ЭМЯ” гэж Хүлээн авагчийн Эрүүл мэндийн яам эсхүл түүний чиг үүргийг залгамжлагч байгууллагыг хэлнэ.
 22. “ОШХ хөтөлбөр” гэж Ковид-19-ийн аюулаас урьдчилан сэргийлэх,

- илрүүлэх, хариу арга хэмжээ авах, нийгмийн эрүүл мэндийн бэлэн байх үндэсний тогтолцоог бэхжүүлэх хүчин чармайлтад ОУСБХБ болон ОУХА-ийн гишүүн улс орнуудад туслах зорилгоор боловсруулсан олон үе шаттай хөтөлбөрийг хэлнэ.
23. “ОБЕГ” гэж Хүлээн авагчийн Онцгой байдлын ерөнхий газрыг эсхүл түүний чиг үүргийг залгамжлагч байгууллагыг хэлнэ.
24. “Үйл ажиллагааны зардал” гэж түрээс, мөн/эсхүл тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн тогтмол засвар, үйлчилгээ, ажлын байр ба оффисын талбай, түлш, бичиг хэрэг, халаалт, цахилгаан болон харилцаа холбооны зардал (шуудан, утас болон интернэтийн гэх зэрэг), тээвэр, орчуулга, хувилж, олшруулах зардал, Ассоциацийн шимтгэл, хэвлэл, сурталчилгааны зардал, даатгал, Төсөлтэй холбоотой уулзалт, томилгоо, аяллын зардал, гэрээт туслах ажилтны цалин болон Төсөлтэй холбоотой бусад захиргааны зардал гэх зэрэг Төслийн үйл ажиллагааг уялдуулан хэрэгжүүлэх, хяналт тавихад шаардлагатай бараа, зөвлөхийн бус үйлчилгээний зохих зардлыг хэлнэ. Гэхдээ үүнд Хүлээн авагчийн төрийн албан хаагчдын цалин, урамшуулал болон түүнтэй адилтгах аливаа төлбөр хамаарахгүй болно.
25. “Хувийн нууцлалтай мэдээлэл” тухайн хүн эсхүл хувь хүнд хамаарах аливаа мэдээллийг хэлнэ. Хувь хүн гэж шууд болон шууд бус байдлаар тодорхой өгөгдөл, эсхүл түүний хослол, эсхүл тэрхүү өгөгдлийн бусад өгөгдсөн мэдээллийн нэгдлийн тусламжтай танигдах боломжтой хүнийг хэлнэ. Хувь хүнийг танихад нэр, таних дугаар, байршлын мэдээлэл, онлайн таних тэмдэг, мета өгөгдөл, тухайн хүний физик, физиологи, удамшлын, сэтгэцийн, эдийн засгийн, соёлын эсвэл нийгмийн хүчин зүйлд хамаарах өгөгдлүүдийн тусламжтай таних боломжтой ба эдгээрээр хязгаарлагдахгүй.
26. “Худалдан авах ажиллагааны журам” гэж Ерөнхий нөхцөлүүдийн Хавсралт дахь 85 дугаар зүйлийн дагуу 2020 оны 11 дүгээр сард батлагдсан “Дэлхийн банкны Хөрөнгө оруулалтын төслийн санхүүжилттэй худалдан авах ажиллагаанд Хүлээн авагчийн баримтлах журам”- ыг хэлнэ.
27. “Ковид-19-ийн Төслийн вакцин” гэж Хүлээн авагчийн нутаг дэвсгэрт түгээлт хийх, маркетинг болон удирдлагаар хангах эрх бүхий Хүлээн авагчийн үндэсний зохицуулах байгууллагаас зөвшөөрөгдсөн, төслийн хүрээнд худалдан авах КОВИД-19-өөс урьдчилан сэргийлэх вакциныг хэлнэ; “Ковид-19-ийн Төслийн вакцин” гэдэг нь олон тоог илэрхийлнэ.



28. “Төсөл хэрэгжүүлэх гарын авлага” гэж энэхүү Хүлээн авагчийн 2020 оны 6 дугаар сарын 12-нд баталсан гарын авлагыг хэлэх ба үүнд (А) үйл ажиллагаа болон ажлын горимын дараах дэлгэрэнгүй зохицуулалтыг тусгасан байна. Үүнд: (а) институцийн зохицуулалт, төслийн өдөр тутмын гүйцэтгэл; (б) зарцуулалт болон санхүүгийн удирдлага; (в) худалдан авах ажиллагаа; (г) байгаль орчин, нийгмийн нөлөөллийн арга хэмжээнүүд; (д) хяналт-шинжилгээ, үнэлгээ, тайлагнал ба харилцаа холбоо; (е) шударга ажиллагааны төлөвлөгөө, (ё) хувийн нууцлалтай мэдээлэл цуглуулах, мэдээлэлд олон улсын шилдэг туршлагын дагуу боловсруулалт хийх, төслийн хэрэгжилтийн хувьд хүлээх чиг үүрэг; (ж) Төсөлд шаардлагатай бусад захиргааны, санхүүгийн техникийн болон зохион байгуулалтын заавар, горим; мөн (Б) “Вакциныг хүргэх, түгээх гарын авлага. Энэхүү гарын авлагыг Ассоциациас урьдчилан бичгээр зөвшөөрөл авсны үндсэн дээр тухай бүр өөрчлөлт оруулж болох бөгөөд үүнд энэхүү зааврын аливаа хуваарь мөн хамаарна.
29. “Төсөл хэрэгжүүлэх нэгж” гэж энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 2-ын I.A.2.(г) хэсэгт зааснаар Хүлээн авагчийн үүсгэн байгуулж, ажиллуулах нэгж эсхүл түүний чиг үүргийг залгамжлагчийг хэлнэ.
30. “Бүс нутаг” гэж Хойд Америк, Өмнөд Америк, Европ, Ази, Ази Номхон далайн бүс, Африкийн бүс нутгийг хэлнэ.
31. “Хэлэлцээр байгуулсан өдөр” гэж Хүлээн авагч болон Ассоциаци хооронд энэхүү Хэлэлцээрт гарын үсэг зурсан хоёр огнооны сүүлийн огноог хэлэх ба энэхүү тодорхойлолт нь Ерөнхий нөхцөлүүдэд дурдагдсан “Хэлэлцээр байгуулсан өдөр” гэсэн заалт бүрд хамаарна.
32. “Оролцогч талуудын оролцооны төлөвлөгөө” гэж Хүлээн авагчийн 2020 оны 11 дүгээр сард баталсан, БОНУАТ-нд заасны дагуу төслийн оролцогч талуудын оролцоог хангах, мэдээлэл ил тод болгох үйл ажиллагаа нь Байгаль орчин, нийгмийн хамгааллын стандартын дагуу явагдаж байгааг баталгаажуулах зорилгоор Ассоциацид хүлээн зөвшөөрөгдсөн байдлаар хэрэгжүүлж буй оролцогч талуудын оролцооны төлөвлөгөөг хэлэх ба Банкнаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авсны үндсэн дээр төлөвлөгөөг тухай бүр шинэчлэх боломжтой.
33. “Хатуу зохицуулалттай байгууллага” гэж ДЭМБ-аас Хатуу зохицуулалттай байгууллага гэж ангилсан Үндэсний зохицуулах байгууллагыг хэлнэ.
34. “Төлөвлөлт, менежментийн техникийн ажлын хэсэг” гэж энэхүү гэрээний 2 дугаар хавсралтын I.A.2 (в) (i) хэсэгт дурдсанчлан

- Хүлээн авагчийн байгуулан ажиллуулж байгаа ажлын хэсгийг; эсвэл түүнийг залгамжлагчийг хэлнэ.
35. “Вакцины нийлүүлэлт, нийлүүлэлтийн техникийн ажлын хэсэг” гэж хүлээн авагчийн энэхүү гэрээний 2 дугаар хавсралтын I.A.2 (в) (ii) хэсэгт заасны дагуу байгуулан ажиллуулж байгаа ажлын хэсгийг; эсвэл түүнийг залгамжлагчийг хэлнэ.
36. “Вакцины хөтөлбөрийг дэмжих техникийн ажлын хэсэг” гэж энэхүү гэрээний 2 дугаар хавсралтын I.A.2 (в) (iii) хэсэгт дурдсанчлан Хүлээн авагчийн байгуулсан, ажиллуулж буй ажлын хэсгийг; эсвэл түүнийг залгамжлагч.
37. “Дэмжлэг үзүүлэх тогтолцоо, дэд бүтцийн техникийн ажлын хэсэг” гэж энэхүү гэрээний 2 дугаар хавсралтын I.A.2 (в) (iv) хэсэгт дурдсанчлан Хүлээн авагчийн байгуулсан, ажиллуулж буй ажлын хэсгийг; эсвэл түүнийг залгамжлагчийг хэлнэ.
38. “Сургалт” гэж төслийн хүрээнд хийгдэх аливаа сургалтын үйл ажиллагаа, семинар, сургалтын аялалд хүмүүсийг оролцуулахад шаардагдах бараа материал, үйлчилгээний боломжит зардлыг хэлэх бөгөөд үүнд сургалтад оролцогсдын унаа, байр хоолны зардал, сургагч багшийн үйлчилгээний хөлс, сургалтын байрны түрээс, сургалтын материал боловсруулах, олшруулах зардал болон семинар эсхүл сургалтын аялал зохион байгуулах, тэдгээрт оролцогчтой холбоотой бусад шууд зардлууд орох ба гагцхүү зөвлөхийн үйлчилгээний хөлс, зөвлөхийн цалин, урамшуулал, мөнгөн шагнал, Хүлээн авагчийн төрийн албаны цалин, хөлсөнд дүйцэх зардлууд багтахгүй.
39. “Вакцин батлах шалгуур” гэж вакциныг (а) гурван (3) бүс нутагт (онцгой үед ашиглах зөвшөөрөл хамаарна) хоёр (2) хатуу зохицуулалттай байгууллагаас зөвшөөрөл авсан; эсхүл (б) ДЭМБ-ын урьдчилсан шатны шалгаруулалтад хамрагдаж, нэг (1) хатуу зохицуулалттай байгууллагаас зөвшөөрөл авсан (онцгой үед ашиглах зөвшөөрөл хамаарна); эсхүл (в) Хүлээн авагч болон Ассоциаци хооронд бичгээр харилцан тохиролцсон бусад шалгуурыг хэлнэ.
40. “Вакциныг хүргэх, түгээх гарын авлага” гэж энэхүү Хэлэлцээрийн 2 дугаар Хуваарийн I хэсгийн 2 дугаар хэсэгт дурдсан Хүлээн авагчийн гарын авлагыг (Хүлээн авагч төсөл хэрэгжүүлэх гарын авлагын нэг хэсэг болгон баталж болно) хэлэх ба Ассоциациас урьдчилсан бичгээр зөвшөөрөл авсны үндсэн дээр гарын авлагыг тухай бүр шинэчилнэ.
41. “ДЭМБ” гэж Дэлхийн эрүүл мэндийн байгууллагыг хэлнэ.

42. “ДЭМБ-ын шударга хуваарилалтын хүрээ” гэж 2020 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн “КОВАКС хөтөлбөрийн хүрээнд КОВИД-19 вакцины шударга хуваарилалтын механизм”-ын ажлын баримт бичигт тодорхойлсон ДЭМБ-ын хуваарилалтын эрэмбийг тодорхойлно: (а) эрүүл мэнд болон нийгмийн хамгааллын салбарт нэн тэргүүний эгнээнд ажиллаж буй ажилтнууд; (б) өндөр настан; (в) нас барах эрсдэл өндөртэй суурь, ужиг өвчтэй иргэд.
43. “ДЭМБ-ын урьдчилсан шалгаруулалт” гэж ДЭМБ-аас тэргүүлэх ач холбогдол бүхий өвчний эмчилгээний чанар, аюулгүй байдал, үр нөлөөг үнэлэх үйлчилгээ үзүүлдэг бөгөөд хөгжиж буй орнуудад НҮБ болон олон улсын худалдан авалтад зориулагдсан үйлчилгээг хэлнэ.

Хэсэг II. Ерөнхий нөхцөлүүдийн өөрчлөлт

Ерөнхий нөхцөлүүдийн 3.02 (б) байдлаар өөрчлөлт орсон.

“(Б) Хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамжийг (i) Үндсэн санхүүжилтийн хэлэлцээр байгуулсан өдрөөс жар хоногийн дараагаас үндсэн зээлийн ашиглагдаагүй байгаа үлдэгдэлд тооцох (Санхүүжилтийн хэлэлцээрт туссаны дагуу), болон (ii) Санхүүжилтийн хэлэлцээр байгуулсан өдрөөс хойш дараах хугацаанаас жар хоногийн дараагаас нэмэлт зээлийн ашиглагдаагүй байгаа үлдэгдэлд тооцох (Санхүүжилтийн хэлэлцээрт туссаны дагуу) ба Хүлээн авагчийн зүгээс санхүүжилтийг зарцуулах эсхүл цуцлах өдөр хүртэл хугацаанд тооцно. Хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамжийг төлбөр төлөгдөх өдрийн өмнөх 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар тогтоосон хувь хэмжээгээр тооцох ба энэхүү хэсгийн дагуу түүний дараа тухай бүр шинэчлэн тогтоох бусад хувь хэмжээгээр тооцно. Жил бүрийн 6 дугаар сарын 30-ны өдөр тогтоох хувь хэмжээг тухайн жилд хийгдэх дараагийн Төлбөр хийх өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. Хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамжийг хагас жил тутам төлнө. Хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамжийг 30 хоногтой арван хоёр сараар буюу жилийн 360 хоногоор тооцно.”

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 4.5

Индекс: 200003